



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-49
1.Хуулийн төсөл эцэслэн батлах	8-9
2.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	9-36
3.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	36-48
4.Баталсан хуулийн эцсийн найруулгыг танилцуулах	48-49

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 09-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 70 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Б.Батцэцэг, П.Батчимэг, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, С.Бямбацогт, С.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Д.Пүрэвдаваа, Б.Пүрэвдорж, О.Саранчулуун, Б.Тулга, А.Ундраа, Д.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, Д.Ганмаа, Д.Үүрийнтуяа; Тасалсан: Ж.Батсуурь, Ш.Бямбасүрэн, Л.Гантөмөр, Ц.Туваан;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-10 минут, Ц.Баатархүү-03 минут, Д.Батлут-01 минут, Ж.Галбадрах-02 минут, Д.Ганбат-11 минут, Ц.Даваасүрэн-12 минут, Т.Доржханд-05 минут, Б.Жаргалан-08 минут, Д.Жаргалсайхан-23 минут, Ж.Золжаргал-07 минут, Т.Мөнхсайхан-03 минут, Ц.Мөнхтуяа-02 минут, З.Мэндсайхан-04 минут, Э.Одбаяр-16 минут, С.Одонтуяа-26 минут, Б.Пунсалмаа-43 минут, Н.Учрал-02 минут, Л.Энх-Амгалан-32 минут, Л.Энхнасан-03 минут, Р.Эрдэнэбүрэн-1 цаг 02 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав. /10:02/

Нэг.Хуулийн төсөл эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 22
Бүгд: 85
74.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 25
Бүгд: 86
70.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 21
Бүгд: 87

Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхын буюу 75.9 хувийн саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Банкны санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундрага, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур,

мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Р.Сэддорж, Б.Батбаатар, Х.Булгантуяа, С.Эрдэнэбат, Ж.Баярмаа, Э.Болормаа, С.Замира, Д.Жаргалсайхан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	53
Татгалзсан:	44
Бүгд:	97

54.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: Төслийн 1 дүгээр зүйлийн “зургаа хүртэлх” гэснийг “таван” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	40
Бүгд:	97

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 36 минут үргэлжилж, 11 цаг 37 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.

Гурав.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодоос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, О.Цогтгэрэл, Б.Түвшин, Б.Хэрлэн, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Баталсан хуулийн эцсийн найруулгыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./14:44/

Уг асуудлыг 14 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 24 минут үргэлжилж, 126 гишүүнээс 97 гишүүн хүрэлцэн ирж, 77.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 01 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

70 гишүүн бүртгэгдэж, ирц 55.6 хувьтай байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар 4 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Хоёрдугаарт, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээр, Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Эцэслэн батлуулах хуулийн төслийн хувилбарыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа.

Гишүүд суудлаа эзэлье. Санал хураалт явагдана. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд суудлаа эзэлье. Эцэслэн батлах хуулийн төслүүд байгаа. Дандаа 64-өөс дээш кнопор явагдана. Далайн Батбаяр гишүүн 10 цаг 5 минут болж байна. Чуулганы хуралдаан 10 цагт эхэлж байгаа. Ирцэд орчихсон байгаа юу? Санал хураалт явагдана. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя.

Санал хураалтад ороогүй гишүүд байна уу? Гараа өргөө.

1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 санал хураалтад хангалттай юм байна. Санал хураалт эхлүүлье.

1.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

63 гишүүн санал өгч хуулийн төсөл, Баасанжаргал горимын санал.

Энэ чинь 70 гаруй гишүүн байсан шүү дээ. Яагаад санал дээр тэгж байна. Баасанжаргал гишүүн

Х.Баасанжаргал: Миний санал сая орсонгүй дарга. Тэгээд горимын санал гаргаад санал хураалтыг хүчингүй болгуулаад дахин санал хураалт явуулах гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Тийм. Танхимын төхөөрөмжид асуудал байхгүй шүү. Байхгүй. Тийм өөрсдөө л хоцорч байгаа байхгүй юу. Энэ ер нь горимын санал гаргахгүй л гээд л удаа дараа л яриад байдаг тэгээд л ингээд л 70, 80-уулаа сууж байгаад л 64 санал өгөх болох дээр л ингээд л асуудал үүсгээд л. Энийг чинь иргэд шүүмжлээд байгаа шүү дээ. Ажилдаа жоохон хариуцлагатай бай л гэж байгаа шүү дээ. Санал өгөхөд 10-хан секунд анхаарлаа төвлөрүүлэх асуудал гишүүд ээ. Санал хураахад 10-хан секунд анхаарлаа төвлөрүүл. Тэгэхгүй ингээд л санал хураагаад л 1 саналаар уначихлаа, горимын санал гаргаж байна гээд л. Энийг чинь гаднаас харж байгаа, хөндлөнгөөс харж байгаа иргэд зөв ойлгодоггүй шүү дээ. Энэ нэг юмнууд ажлаа хийж чадахгүй, юмаа ойлгохгүй л гэж л хардаг шүү дээ.

Баасанжаргал гишүүний гаргасан горимын саналаар 1 удаа горимын санал хураалт явуулъя. Ер нь цаашдаа жоохон хатуу байсан нь дээр байх. Аль аль талдаа бид шүүмжлэлд их өртөж байгаа шүү. Горимын санал. Санал хураалтыг хүчингүй болгохоор санал хураалт явуулъя.

61 санал буюу 70.9 хувиар санал хураалт хүчингүй боллоо.

Санал хураалт Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66 гишүүн буюу 75.9 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөл эцэслэн батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Амгаланбаатар гишүүнд бас баяр хүргэе. Анхны хуулийн төсөл санаачлаад төслөө амжилттай Улсын Их Хурлаар дэмжүүлсэнд баяр хүргэе.

Дараагийн асуудалд оръё. Дамдинням гишүүн ээ хоёулаа ээлжилж ярих уу, эс үгүй бол та энд суугаад ярьчих. Дараагийн асуудалд оръё.

10.08 цаг

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна. Индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Батшугараас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 4 дүгээр сарын 25, 5 дугаар сарын 2-ны өдөр нэгдсэн хуралдаанаар тус тус явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн зарим зарчмын зөрүүтэй саналын томьёолол хууль, тогтоолын төслийн заалт хоорондоо зөрчил үүсгэсэн байсан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь эдгээр саналуудаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзэн дараах санал хураалтуудыг явууллаа.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийг 14.3 олон улсын жишиг зарчмыг

баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэхүү хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно гэсэн зарчмын зөрүүтэй санал болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийг хуулийн төслийн холбогдох заалттай нийцүүлэх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь буюу дийлэнх олонх нь дэмжсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан саналуудыг хууль, тогтоолын төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дарааллыг жигдлэн, хууль зүйн техник засваруудыг хийж хууль, тогтоолын төслийн эцсийн хувилбар болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Бэгзийн Итгэлсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга хааччихсан юм? Итгэлсүрэн хааччихсан юм? Энэ Тамгын газар энэ танхимд орж ирээгүй хүний нэр өгч надад уншуулдгаа болиорой. Орж ирсэн төрийн албан хаагч үнэн, зөв хариулт өгнө гэдэг үүрэг хүлээх байтал бүр орж ирээгүй төрийн албан хаагчийн нэр өгч уншуулдгаа болих хэрэгтэй шүү. Өлзийбатын Мөнх-Ундарга Монголбанкны Санхүүгийн эрх зүйн хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Ирцийн дарааллын дагуу Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Улсын Их Хурлын гишүүн Батшугарын өргөн барьсан энэ Зээлийн мэдээллийн тухай хуулийг дэмжиж байгаа. 2 ч шалтгаан байгаа.

Нэгдүгээрт энэ 200 гаруй мянган хүн тэр хар жагсаалт гэдэгт орчихсон, гар утасны төлбөр төлсөн, төлөөгүй янз янзын шалтгаанаар орчихсон энэ хүмүүсийн санхүүгийн энэ хар жагсаалт нь байхгүй болоод санхүүгийн оноо гэдэг энэ олон улсын хэв маяг руугаа орох энийг дэмжиж байгаа.

Хоёрдугаарт энэ хууль батлагдсаны дараагийн нэг том ач холбогдол бол зээлийн хүү буурна. Зээлийн хүүд байгаа тэр эрсдэлийн хүчин зүйлүүд бас багасна гэдэг ийм зүйл байгаа. Тэгэхээр би 2 асуулт, 3 асуулт байгаа үндсэндээ.

Хар жагсаалт буюу энэ асуудал ингээд хууль батлагдсанаар шийдэгдээд явчихна. Зээлийн хүү буурна гэдэг энэ асар өндөр ач холбогдолтой энэ зүйлийг ер нь Монголбанк ч тэр хууль санаачлагчийн хувьд яаж хүлээж авч байгаа вэ? Ийм бололцоог ер нь аль болох хурдан бий болгох ямархуу алхмууд хийхээр төлөвлөж байгаа вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ Монгол Улсын хэмжээнд энэ тэтгэвэр, мөн тэтгэмж авч байгаа энэ 5, 600 мянган хүний асуудлууд байна. Энэ хүмүүс өөрсдөө оногдсон тэтгэврээрээ бас эдийн засгийн эргэлтэд оруулаад зээл хувь аваад өрхийнхөө орлого, өөрийнхөө орлогыг бас нэмэгдүүлээд явдаг олон хүмүүс энэ зээлийн, тэтгэврийн зээлийн энэ асуудал дээр нэлээн эмзэг хандаж байна. Холбогдох яамнаас нь энэ 3 сарын 7-ноос хэрэгжсэн энэ журмаа жоохон зөөлрүүлээч гэдэг хүсэлтийг Монголбанкинд ирүүлсэн. Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Энхтайван ерөнхийлөгч харин маш ажилд шуурхай хандаж байгаа. Би бас баяртай байгаа. Энэ зээлийн мэдээллийн зээлийн, тэтгэврийн зээлийн нөхцөлийг 6 сарын 24, 7-ноос хэлэлцэнэ гэсэн ийм зүйлийг оруулж ирж байна лээ. Миний хувьд хугацааг нь жоохон наашлуулаад тэгээд хуучнаар нь болгоод энэ тэтгэвэр, тэтгэмжээ өөрсдөө эргэлтэд оруулаад 5, 3 төгрөгөө өсгөөд ингээд явах бололцоог нь аль болох л хурдан бүрдүүлж өгөөч гэж ингэж хүсэх гэж байгаа юм.

Тэтгэвэрт гарсан хүний сэтгэл зүй гэдэг бас арай өөр байдаг л даа. Тэтгэврээ аваад зүгээр суухаасаа илүүтэйгээр тэр өөрт байгаа санхүүгийн эх үүсвэрээ эргэлтэд оруулаад орлого олоод ингээд явах нь өөрт нь ч хэрэгтэй, сэтгэл санаа бүхий л зүйлд нь хэрэгтэй байдаг л даа яг тэтгэвэр аваад сууж байгаа хүний хувьд. Сэтгэл зүйн хувьд ч гэсэн шал өөр байдаг юм байгаа юм.

Тийм учраас энэ дээр Монголбанк заавал тэр 6 сарын 20 хэдэн гэхгүйгээр энэ асуудлыг шийдэж өгөөч. Энэ цэрэг цагдаагийнхан бас маш залуугаараа тэтгэвэрт гардаг шүү дээ. 40 жоохон гараад л тэтгэвэрт гарчихсан ийм хүмүүс зүгээр тэтгэвэр хараад суухгүйгээр өөр эргэлтэд оруулъя гээд. Энэ нь ч бас бидэнд ч гэсэн, энэ улс оронд ч гэсэн хэрэгтэй байх гэж ингэж бодож байгаа.

Гурав дахь асуулт Улсын Их Хурлын дарга энэ зээлийн хүү бууруулах тал дээр нэлээн онцгой ач холбогдол өгч байгаа. Улсын Их Хурлаас манай Зүүн бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүн Соронзонболдоор ахлуулсан зээлийн хүү бууруулах ажлын хэсэг бүр байгуулагдаад ажиллаж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ зээлийн хүү бууруулах энэ асуудлыг эхлүүлэхдээ энэ хуультайгаа уялдуулаад энэ хамгийн эрсдэл багатай гэдэг энэ тэтгэврийн зээлийн хүүг бууруулахаас ажлаа эхлүүлэх бүрэн дүүрэн бололцоо бас байгаа гэдгийг энэ Их Хуралд байгаа энэ эдийн засаг, энэ банкны салбарынхан хэлээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр ер нь Монголбанк ямархуу бодлого баримтлах юм байгаа юм. Энэ дээр хууль санаачлагчийн хувьд ч гэсэн бас ямар бодолтой байгаа юм бэ? Бололцоо байгаа гэдгийгээ бас бидэнд тайлбарлаж өгөөч гэж гэсэн ийм үндсэндээ 3 асуулт байна. Тэгээд Их Хурлын дарга түрүүчийн хуралдаан дээр бас хариултаа би гүйцэт авч чадалгүйгээр хугацаа дуусчихсан. Тийм учраас энэ хариултыг бас сайн дэлгэрэнгүй авхуулж өгөөч гэж бас хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуултад хариулъя.

Э.Батшугар: Эрхэм гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Идэрбат гишүүний асуултад хариулъя зээлийн хүү буурах уу гэж асууж байна. Зээлийн хүү буурна. Үндсэндээ 3 шалтгаан байгаа юм. Нэгд нь бол банкнуудын эрсдэл нь өөрөө буурна, эрсдэлээ тодорхойлдог болно. Тэгэхээр сайн зээлдэгч нар болон өндөр оноотой зээлдэгч нараа илүү урамшуулдаг, сайн нөхцөлөөр зээл олгодог болно.

Дээрээс нь нэмээд ялангуяа малчдын ахмадуудын зээл байгаа юм. Тэр нь байнга, тогтмол төлдөг зээлийн оноо нь өсөөд үүнийгээ дагаад эрсдэл нь буураад тэр нь бол шууд хүүгээр илэрхийлэх юм.

Хоёрт нь банкнуудын урсгал зардал гэж байгаа юм. Тэр нь буурна. Бид нар чинь ярьдаг шүү дээ таньдаг эдийн засагч байна уу гээд л янз янзын юмнууд яг бодит амьдрал дээр. Тийм юм байхгүй болох юм. Нэг утгаараа шууд оноогоо үзүүлээд тэр нь тухайн зээлдэгчийг тэр чигээр нь илэрхийлчхэж байгаа болохоор шууд л санхүүгийн үйлчилгээгээ өгөх тийм суурь нөхцөл үүсчхэж байгаа юм.

Мөн үүнтэй холбоотойгоор нэг зүйл байгаа юм. Өнөөдөр том хэдэн банкнууд байгаа тэд нар харилцагчийнхаа мэдээллийг хуваалцдаггүй, шэйрлэдэггүй. Тэгэхээр тэр том банкны л нөхцөлөөр санхүүгийн үйлчилгээ аваад байгаа юм. Харин энэ онооны системтэй болсноор дуртай санхүүгийн байгууллагууд очоод оноогоо үзүүлээд тэгээд санхүүгийн үйлчилгээгээ, зээлээ авах бололцоо нь үүсэж байгаа юм.

Тэгэхээр нэг ёсондоо санхүүгийн байгууллагууд хоорондоо бас хүүгээрээ, мөн таатай нөхцөлөөрөө өрсөлдөх нөхцөл байдлыг үүсгэж байна гэж ойлгож болох юм. Цаашлаад яривал барьцаа хөрөнгийн шаардлага ч гэсэн буурна. Яагаад гэвэл оноо нь өөрөө санхүүгийн биет бус хөрөнгө болчхож байгаа юм. Тэгэхээр энэ бас шаардлагууд буураад санхүүгийн хүртээмж нэмэгдэх суурь нөхцөл үүсэж байгаа юм.

Бас та Идэрбат гишүүн тэтгэврийн зээлийг ярь ярьж байна. Тэтгэврийн зээл ч гэсэн мөн адилхан. Манай ахмадууд бол сар болгон л тэтгэврийн зээлээ төлдөг. Нэг ёсны банкнууд ер нь автоматаар суутгачихдаг шүү дээ. Энэ чинь эргэн төлөлт гэсэн үг. Тэгэхээр оноо нь нэмэгдээд цаашлаад үүнийгээ дагаад суурь хүү нь буурах нөхцөл үүсэж байгаа юм.

Ер нь тэтгэврийн зээл чинь бол нэг ёсны бараг л эрсдэлгүй зээл гэсэн үг ч болно шүү дээ. Заавал арилжааны чанартай зээл биш. Арилжааны чанартай зээлтэй адилхан банкнууд болон санхүүгийн байгууллагууд тэтгэврийн зээлээр ашиг олоод байх нь буруу гэж бодож байгаа юм. Яагаад гэвэл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас автоматаар сар болгон тавьдаг. Маш ойлгомжтой. Хэд дэх өдөр зээлийн, хэд дэх өдөр тэтгэврийг нь тавьдаг нь ойлгомжтой байдаг. Тэр нь банкнууд шууд суутгачихдаг. Нэг ёсны тогтмол орлоготой, энэ нь эрсдэл багатай. Үүнийгээ дагаад зээлийн хүү ч гэсэн бас бага байх ёстой гэж харж байгаа юм.

Үлдсэн асуултаа бас Монголбанкнаас асуусан байгаа. Монголбанк тодруулж хариулна байх.

Д.Амарбаясгалан: Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн асуулт асууя.

Р.Сэддорж: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Зээлийн мэдээллийн сангийн энэ хуулийг өөрчлөх хууль оруулж ирсэн Батшугар гишүүний хуулийг дэмжиж байгаа. Бидний гол зорилго ялангуяа Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн байнга ярьдаг энд зээлийн хүүг бууруулахад юу хийх ёстой вэ гэдэг дээр олон ажлуудыг ярьж, ажлын хэсгүүд эхнээсээ гарч байна. Соронзонболд гишүүнээр ахлуулсан зээлийн хүүг бууруулах Улсын Их Хурлын өмнө нь гарсан тогтоолын хэрэгжилтийг хянах ажлын хэсгийг Соронзонболд гишүүнээр ахлуулж гаргасан.

Тэгээд Батшугар гишүүнээс дахин асууя. Энэ зээлийн хүүг бууруулах, буурна гэдэг дээр бид итгэлтэй байгаа. Энэ мэдээллийн сан, мэдээллийг онооны системд шилжүүлснээр олон хүндрэлтэй асуудлууд шийдэгдэнэ гэсэн ийм хүлээлтүүд байгаа. Танд бас олон удаа хэлж байсан хар, цагаан жагсаалтаа салгаад хар жагсаалтаа тусад нь тэр урт хугацаагаараа 5 жилээрээ хар, цагаан жагсаалт гэдэг юм уу тэр жагсаалтаа арай бага хугацаагаар ингээд яаж болохгүй юу? Энэ дээр Монголбанкнаас дараагийн хууль хэзээ орж ирэх вэ? Батшугар гишүүн энэ дээр ямар бодолтой байна? Монголбанк бас ямар бодолтой байна? Энэ хуулийг бас өөрчлөх шаардлага бол байгаа. Дараагийн өөрчлөлт хэзээ орж ирэх вэ?

Монголбанкнаас тэтгэврийн зээлийн хязгаарлалтыг 3 сарын 7-нд хийсэн. Сая бас гишүүд хэлж байна. Тэгээд энийгээ яг 6 сарын хэдэнд өөрчлөх вэ? Энд иргэд, сонгогчдоос маш их асуулт, гомдол ирж байгаа. Тэгээд энэ дээр дорвитойхон хариулт өгөөдөх. Мэдээж бас Их Хурлын гишүүд шууд нөлөөлж болохгүй байх. Мөнгөний бодлогын зөвлөл эд нар байгаа. Энэ дээр бас бодитой, тодорхой, бас баримжаатай хугацаа, хариулт хэлээч. Малчдын тэтгэврийн зээлийг 60:40 байсныг 70:30 болгож ингэж бас чангалсан, багасгасан байгаа. Энэ дээр тэтгэвэр авдаг иргэд маань нэлээн бухимдалтай байна. Энийг сайжруулахгүй юм гэхэд хуучнаар нь байлгаж өгөөч л гэж байгаа юм. Энэ дээр хариулт авъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя Батшугар гишүүн.

Э.Батшугар: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Тийм зээлийн хүү Монгол Улсад үнэхээр өндөр байгаад байгаа. Үүнтэй холбоотойгоор судалгаа хийхэд бол нийт зээлийн хүүг 100 хувь гэж бодвол 63 хувь нь бол эх үүсвэрийн зардал, нэг ёсны хадгаламжийн хүү байгаа юм. Үүн дээр бол шууд инфляц гэх мэтчилэн суурь макро эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой болохоор их маневр хийхэд хэцүү. Гэхдээ үлдсэн 27 хувьд нь маневр хийж болж байгаа.

Жишээлбэл эрсдэл нь бол 15 хувь гэж байгаа юм хүүнийх нь. Мөн үйл ажиллагааны зардал нь 22 хувь. Тэгэхээр энэ онооны системтэй болсноор эрсдэлийг нь бууруулж энэ 15 хувь дээр нь тодорхой хэмжээний тохиргоо хийж болно. Мөн урсгал зардал болон 22 хувь дээр нь бас тодорхой хэмнэлт хийж болж байгаа юм.

Яагаад гэвэл эдийн засагч чинь 2 долоо хоног судална гэх мэт зүйл байхгүй шууд оноон дээр нь сууриалаад тэгээд зээл нь олгоно. Латин Америк дээр яг үүнтэй

холбоотой судалгаа хийсэн юм байна лээ. Өмнө нь бол 2 долоо хоног зээл олгодог байсан бол энэ онооны системтэй шилжсэнээр 0.6 хоног. Нэг ёсны ажлын өдөртэй олгож эхэлж байгаа юм зээлийн шийдвэр нь.

Зээлийн хүү энэ онооны системтэй холбоотойгоор бас буурсан 28 оны судалгаа байгаа юм. 2004-2019 оны хооронд энэ онооны систем рүү шилжсэнээр зээлийн хүү дунджаар 3.2-3.8 хувиар буурсан тийм тооцоо гарсан. Хамгийн сүүлийн кейс бол яг Вьетнам Улс байгаа юм. Вьетнамд бол 2000 оны эхээр зээлийн хүү нь яг манайхтай адилхан 18-20 хувьтай байсан. Кредит скоринг болон онооны систем рүү шилжсэнээр бол энэ нь бол 12-14 хувь руу буурсан. Нэг ёсны 5 нэгж хувиар буурсан тийм үзүүлэлт гарч байгаа юм.

Энэ хар лист гээд байгаа зүйл байхгүй болно. Блэк лист/black list/ болон хар жагсаалт гэсэн зүйл байхгүй болно. Үүнтэй холбоотойгоор харин мэдээлэл нь 5 жилээр хадгалагдана. Гэхдээ энэ сайн ч мэдээлэл, муу ч мэдээлэл хадгалагдана. 5-аас доошлуулчихвал нэг ёсны манайх чинь бас санхүүгийн бүтээгдэхүүнээ илүү өргөжүүлээд бизнесийн зээлээ бас 5-аас дээш жил олгодог болгох гээд үзээд байгаа. Энэ хувьд бас сайн зээлдэгч нарын ч гэсэн мэдээлэл нь хадгалагдах юм.

Харин эсрэгээрээ хуулийн төсөлтэй холбоотой тогтоолд орж байгаа энэ нь бол зээлдэгчээс үл хамаараад орлого нь хаагдсан, нэг ёсны гал, үерийн ослын аюул ч юм уу, аль эсвэл КОВИД ч юм уу ийм нөхцөл байдлаас болоод зээлээ төлж чадахгүй бол Монголбанкнаас журам батлаад илүү уян хатан хандах байдалдаа оруулахаар тийм тогтоол баталчихсан.

Харин эсрэгээрээ Хөгжлийн банкны зээл, дээрээс нь нэмээд Засгийн газрын Тусгай сангийн зээл авчихсан бол тэр байдал нь ийм уян хатан байдалд орохгүй гэж байгаа.

Яагаад гэвэл Засгийн газрын мөнгө гэдэг чинь татвар төлөгчийн мөнгө, улс орны татвар төлөгч гэдэг чинь энэ мөнгөтэй харьцаж байгаа улсууд илүү хариуцлагатай.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Зээлийн мэдээллийн сангийн хуульд өөрчлөлт оруулах гэж байгааг дэмжиж байгаа. Ер нь бид нар Монголын санхүүгийн зах зээл, санхүүгийн систем өөрөө сүүлийн энэ шинэ өөрчлөлтөд орсноос хойших сүүлийн 30 гаран жилийн хугацаанд үндсэндээ өөрчлөлт их бага явлаа. Банкнуудын лобби Улсын Их Хурал шийдвэр гаргах түвшинд тодорхой хэмжээгээр оролцоод бусад санхүүгийн зах зээлүүд хөгжихгүй байна гэдэг ийм дүгнэлт хийхэд хүрч байгаа. Уул нь банк, санхүүгийн зах зээлийн 30 орчим хувь ч байдаг юм уу, хөрөнгийн бирж, хувьцаа, бусад санхүүгийн зах зээл нь илүү том орон зайг эзэлдэг байвал илүү сайн болох юм байгаа юм гээд. Иргэний зориг ногоон намын эрдэмтэн судлаачид, ажлын алба зээлийн хүүний дээд хязгаарыг тогтоох, хязгаарлах тухай хуулийн төсөл бэлдэж ажиллаад бараг дуусаж байгаа. Их Хурал дээр ч гэсэн энэ талын ажлын хэсэг байгаа. Тэгэхээр энэ асуудалд анхаарлаа хандуулж ажиллахгүй бол энэ Монголд хөдөлмөр эд эрхэлж байгаа бараг бүх хүн энэ 3 сая, 2 сая Монголчууд бүгдээрээ банкны, ломбардын, банк бусын ажилчид болоод хувирчихлаа. Тэдний хүүг өсгөж өгдөг. Ашигтай ажилласан 100 аж ахуйн нэгж

хамгийн өндөр татвар төлсөн гээд харахад тэр дотор эзэлдэг аж ахуйн нэгжийн тоо банк санхүү, уул уурхай 2 дээр л үндсэндээ төвлөрч байна.

Тэгэхээр энэ нь өөрөө юуг хэлж байна вэ гэхлээр эргээд иргэдийгээ хязгааргүй хүүгийн дарамтад оруулж тэд нарынхаа хөдөлмөрийг шулаад байна гэдэг ийм л байдал руу харуулаад байгаа юм. Тэгээд энэ их маш бага тоо байдаг байх. Зээл авдаггүй юм уу, ер нь зээлгүй байгаа хүний тоо гэж тийм тоо юм уу, хувь хэмжээ байдаг юм уу? Байдаггүй юм болов уу? Бараг бүх хүн зээлтэй болов уу л гэж харагдаад байгаа юм. Хэрвээ тийм хүмүүс байдаг бол тэд нар энэ мэдээллийн санд яаж бүртгэгдэх вэ? Энэ тухайд тодорхой зохицуулалтууд орох уу, орохгүй юу? Зээлийн зээлжих зэрэглэл мэдээлэлтэй болж байгаа иргэд тодорхой зээлүүдийнх нь тэр нөхцөл, байдал, давагдашгүй хүчин зүйлүүд болон бусад асуудлууд дээрээ мэдээлэлд нь өөрчлөлт орох уу, чанарын өөрчлөлт орох уу? Монголбанкны гаргах гэж байгаа журам нь хуулиа дагаад Монголбанк журамлах юм байна лээ. Тэгэхээр тийм журмаа урьдчилж төсөөлсөн зүйл байдаг юм болов уу, байдаггүй юм болов уу гэдэг энэ тухай асууж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуултад хариулъя.

Э.Батшугар: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь онооны системд шилжсэнээр бол санхүүгийн хүртээмж өөрөө өсдөг, нэмэгддэг. Ялангуяа анх удаа зээл авах гэж байгаа болон санхүүгийн үйлчилгээ авах гэж байгаа иргэдийн тоо нэмэгдсэн тийм олон улсын судалгаа байна л даа. Латин Америкт бол энэ онооны системдээ шилжсэнээр нийт анх удаа зээл авч байгаа иргэний тоо нь 16 хувиар нэмэгдсэн байгаа юм. Энэтхэгт бол энэ бол бүүр өргөн хүрээгээр нэмэгдсэн. Нэг ёсны 119 сая иргэн шинээр зээл авах бололцоог нь үүсгэсэн. Ялангуяа энэ нь бол эмэгтэйчүүд байгаа юм. Алслагдсан нутаг дэвсгэрт амьдардаг иргэдийн тоо чинь илүү хүртээмжтэй болж нэмэгдсэн тийм үзүүлэлт, судалгаа гарсан.

Тэгээд анх удаа зээл авч байгаа иргэн ямар оноотой байх вэ гэж байна. Энэ нь бол дефолт оноо гээд нэг ёсны анхдагч оноо байна. Энэ нь бол муу ч биш, сайн ч биш дунд гэж ойлгож болно. Тэгээд зээлээ авчхаад эргэн төлөлтөө хийгээд яваад байгаа оноо нь өсөөд явчихна. Эргэн төлөлтөө хийхгүй бол оноо нь буурна. Тэгэхдээ эргэн төлөлтөө ахиад хийгээд эхэлбэл оноо нь өсөөд явчихна. Одоо байгаа систем яадаг гэхээр эргэн төлөлтөө хийхгүй бол хар жагсаалтад орчихно. Тэгээд зээлээ төлчихсөн ч гэсэн бид нарын яриад байдаг 6 жилийн санхүүгийн ял нь байгаад байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ систем болиод бодит горимоо динамикаар явдаг онооны систем рүү орох юм. Давагдашгүй хүчин зүйлтэй холбоотойгоор тогтоолын төсөл орж байгаа. Энэ нь бол тухайн иргэнээс, аж ахуйн нэгжээс хамаарахгүйгээр орлого нь тасалдвал тэгвэл илүү уян хатан байдлаар хандана. Харин эсрэгээрээ Хөгжлийн банкны зээл авсан иргэд болон аж ахуйн нэгж Засгийн газрын тусгай сангаас зээл авчхаад тэгээд төлөхгүй байгаад байгаа энэ уян хатан байдалд нь хамаарахгүй гэсэн тийм тогтоолын төсөл орж байгаа юм. Тийм агуулгатай.

Яагаад гэвэл улсын төсвийн мөнгө, Хөгжлийн банкны мөнгө, Засгийн газар тусгай сан чинь бол Монгол Улсын иргэдийн татвар төлөгчдийн л мөнгө. Тийм болохоор илүү хариуцлагатай байх ёстой гэсэн өнцгөөс нь.

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван ерөнхий асуултуудад багцлаад хариулт өгье.

Г.Энхтайван: Улсын Их Хурлын гишүүдийн тавьсан асуултуудад хариулъя. Түрүүн Сэддорж гишүүн болон Идэрбат гишүүн тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлыг хөндлөө. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо өнгөрсөн 3 дугаар сард хуралдаж тэтгэврийн зээл барьцаалж авч, тэтгэвэр барьцаалж авч байгаа зээл дээр тодорхой хэмжээний зохицуулалт хийсэн байгаад байгаа.

Зохицуулалтын хүрээнд тухайн зээл аваад зээлийн эргэн төлөлтөөс гадна үлдэж байгаа хэсэг нь тухайн ахмад настны өөрийн амьжиргааг залгуулах хэмжээнд байх тийм зохицуулалтыг хийж өгөөч гэдэг хүсэлтийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тавьсны үндсэн дээр бид бүхэн энэ зохицуулалтыг хийсэн байгаад байгаа.

Монголбанк Мөнгөний бодлогын хороо хараат бусаар хуралдаж шийдвэрээ гаргадаг. Дараагийн хурлын тов 2 дугаар улиралд хуралдаж энэхүү шийдвэрийг хэлэлцэнэ. Тэгэхээр энэ дээр ямар нэг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу? Тэгье, ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Хараат бусаар хуралдаад энэхүү шийдвэрийг баталдаг. Дараагийн хурал 2 дугаар улиралд хэлэлцэгдээд явна. Идэрбат гишүүн яг энэ асуудал дээр олон нийтийн зүгээс тавьж байгаа асуудлыг удаа дараа хөндөж тавьсан. Бид бүхний зүгээс ч гэсэн энэ асуудлыг эргэн харах боломжтой гэж үзэж байгаа. Засгийн газраас энэ саналаа буцааж хуучин горимд нь оруулъя гэдэг саналаа илэрхийлсэн байгаад байгаа.

Зээлийн дундаж хүү яг одоогийн байдлаар 17 хувьтай жигнэсэн дундаж хүү. Үлдэгдлээр нь тооцох юм бол 16.1 хувийн зээлийн, зээлүүдийн үлдэгдлийн хүү тийм байгаад байгаа. Тэгэхээр энэ зээлдэгчийн оноог зах зээлд нэвтрүүлснээр санхүүгийн зах зээл дээрх дэд бүтэц маань сайжраад яг үүнийгээ дагасан зээлдэгчийг таньж мэдэх функц арилжааны банкин дээр илүү боловсронгуй болгоё. Тэгэхээр зээлдэгчийг таньж мэдэх функц маань өөрөө банкны эрсдэлийн зардлыг тодорхой хэмжээнд бууруулсны үндсэн дээр зээлийн хүүтэй холбоотой.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Энэ хуулийн төслийг дэмжиж байна. Бидний хувьд ялангуяа зээлийн хүүг бууруулахад эрсдэл ихтэй зээлдэгч нарын эрсдэлийг эрсдэл багатай бага хүү хэмжээний зээл авдаг хүмүүст үүрүүлээд байгаа. Үүнээс гарахад нэн чухал юм гэж үзэж байгаа. Тийм учраас энэ хуулийн төслийг дэмжиж байна.

Харин хэдэн зүйлийг бас үүнтэй Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь хамтарч хийгээсэй гэж бодож байна.

Нэгдүгээрт, иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулаасай. Энэ ингээд л муу зээлийн түүх үүсчихэд дараа нь тэрийг арилгахад их хэцүү. Ингээд ерөөсөө

насан туршдаа шахам тэр хүн дандаа өндөр хүүтэй зээл авдаг, эс үгүй бол зээл авч чадахгүй гээд ингээд бизнес эрхлэхэд ч хүнд нөхцөл байдал руу ордог учраас зээл, манай Монголчууд чинь зээлийн санхүүгийн сахилга бат жоохон муутай. Дээрээс нь нэмээд бид нар энэ үүх түүх дээрээ анхаарахгүй байж байгаад хувь хүн өөрөө өөр өөр дээрээ муу зээлийн түүх үүсгэчих вий дээ. Тийм учраас санхүүгийн боловсролыг сайжруулах дээр сайн ажиллах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт энэ надад, хувь хүнд өөрт анзаарагдсан нь гадаадад амьдарч байхад энэ банк санхүүгийн байгууллагаас зээл авахаас өөр аргагүй юм руу бас жоохон түлхээд байдаг юм байна лээ. Тэгэхгүй бол түүх үүсдэггүй хувь хүн дээр. Тийм болохоор хэдийгээр хувь хүн өөрийнх нь данс дээр бараг мөнгө байсан ч гэсэндээ заавал кредит карт аваад, зээлийн карт аваад, зээллэг авч байж өөрөө өөр дээрээ зээлийн түүх үүсгэхгүй бол дараа нь ипотекийн зээл авахад ч байдаг юм уу, цалингийн зээл авахад ч байдаг юм уу өөр ямар нэгэн зээл авах болохоор л тан дээр зээлийн түүх үүсээгүй байна гээд байдаг. Үгүй миний данс дээр уг нь мөнгө байгаа шүү дээ гэсэн ч зээлийн түүх гэдэг зүйл маш их чухал болчихоод байдаг учраас зээл рүү иргэдийг түлхээд байдаг тийм нийгэм харагдсан Америкт. Тэгэхээр үүн дээр бас анхаармаар харагдаж байна лээ.

Гуравдугаарх нь энэ тэтгэврийн зээлийн асуудал дээр та хэд минь юу хийчхэв дээ? Яг үнэнийг хэлэхэд иргэдийн тэтгэвэр хангалттай их биш байгаа энэ цаг үед бид нар нөгөө талд нь энэ тэтгэврийн зээл дээр хүмүүсийн ер нь аваад сурчихсан, яг бүүр тэрүүнийгээ хэмжээд сурчихсан, хэрэглээд сурчихсан мөнгөнд хамаагүй гар хүрнэ гэдэг их хэцүү байдаг Монголбанкныхан. Тэгэхээр үүн дээр та нар судалгаа энэ тэр хийж байж үүн дээр гар хүрэхгүй дээ. Тэртээ тэргүй тэтгэврийн хэмжээ хангалттай их биш байхад ахиад дээрээс нь нэмээд ингэж хамаагүй тэтгэврийн зээлийн хэмжээг хязгаарлана энэ тэр гэдэг тэгээд яах вэ хэдэн хүмүүсийн 5, 10 хүмүүсийн 10 хувь эрх ашиг нь зөрчигдөөд байгаа асуудлууд байх юм бол Ахмад настны тухай хуулиар угаасаа энийг хууль шүүхийн байгууллагад хандах, Зөрчлийн хуулиар хүүхэд эцэг, эхийнхээ тэтгэврийг хүүхдүүд нь хууль бусаар аваад, хүчирхийлж аваад энэ тэр урдаас нь аваад үрээд байх юм бол үүнийг угаасаа хариуцах яах хэрэгтэй байгаа шүү дээ хуулийн дагуу хариуцлага хүлээх хэрэгтэй байгаа. Тэгэхэд үүнийг яагаад ингээд хамаагүй гар хүрчхэв? Тэгэхээр иймэрхүү асуудлууд дээрээ та бүхэн маань цаашдаа жоохон хариуцлагатай хандмаар байна.

Энэ Монголбанк ер нь энэ СЗХ-н дээр сая Улсын Их Хурлын дарга очиж бас ажилласан. Улсын Их Хурлын дэргэдэх Байнгын хороодын дарга нар, Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд Монголбанкна дээр бид бас очиж ажилласан. Энэ зээлийн хүү бууруулах тал дээрээ та бүхэн маань жоохон дорвитой арга хэмжээ авмаар байх юм. Бид нар 1990-ээд оноос ингээд л өнөөдөр төдийгөөс өдий болтол банкны системээ эвдчихгүй юм сан, банкны системдээ хамаагүй гаднын нөлөөлөл оруулчихгүй юм сан гэсэн байдлаар төдийгөөс өдий болтол явахад нөгөө талдаа ерөөсөө шинэ байдлаар яг иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, энэ ялангуяа зээлийн хүүг бууруулах тал дээр ийм алхмуудыг хийе гэж энэ банкны холбооны зүгээс ч байдаг юм уу, Улсын Их Хуралтайгаа энэ хууль тогтоогч байгууллагатайгаа, Монголбанктайгаа ч гэсэн ер нь нээлттэй ажиллаж байгаа тал төдийлөн сайн харагдахгүй байна. Одоо иргэдийн дунд ерөөсөө хамгийн бухимдалтай сэдэв зээлийн хүү болсон. Тэгээд үүн дээрээ манай ингээд хувь гишүүн, Батшугар гишүүн өөрөө энэ хуулийг санаачлаад өргөн бариад явж байна

шүү дээ. Гэтэл уг нь үүнийг Монголбанкнаас санаачлаад, Засгийн газраас, Сангийн яамнаас ч байдаг юм уу өргөн бариад батлуулах бас нөгөө талдаа бүрэн боломжтой байсан юм биш үү?

Д.Амарбаясгалан: Батшугар гишүүн хариулт өгье.

Э.Батшугар: Булгантуяа гишүүн маш чухал асуултыг хөндлөө л дөө. Энэ санхүүгийн боловсрол, иргэдийн санхүүгийн боловсрол гэдэг чинь маш чухал. Тэгээд энэ онооны систем рүү орсноороо бол бас юу харагдсан бэ гэхээр бусад орнууд судалгааг харахад бол энэ Файнаншиал пруденци /financial prudence/ гэж Англиар ярьдаг, мөн Файнаншиал литерси/financial literacy/ гэж ярьдаг. Тэгэхээр энэ нь нэмэгддэг юм байна лээ. Энэ юугаар илэрхийлж байсан бэ гэвэл нийт системийн чанаргүй зээлийн хувь нь 1.9 нэгж хувиар буурсан тийм үзүүлэлт гарсан. Энэ нь бол 2004-2019 оны хооронд 28 оны судалгаан дээр.

Гэхдээ цаашлаад ч гэсэн энэ Монгол Улс ч гэсэн хэрэгжих бололцоотой гэж харж байгаа юм. Монголбанкнаас санхүүгийн боловсролыг дэмжих тийм хөтөлбөр явдаг байсан Дэлхийн банкны санхүүжилтээр. Энэ нь үргэлжлээд явж байгаа юм уу, үгүй юү бас Монголбанк тодруулна байх.

Энэ онооны систем таны хэлж байгаа зөв. Яг Америк болон бусад улс орнууд бол заавал зээл авч байж, кредит карттай болж байж, зээлийн картаа авч байж оноо нэмэгддэг. Гэхдээ энийг бол Монголд бол яг тиймээр нутагшуулах нь буруу гэж дотроо бодож байгаа юм. Тийм болохоор тодорхой яг тоглоомынх нь дүрмийг нь Монголбанк батлаад тэгээд тусгай зөвшөөрөлтэй 2 компани нь өөрсдийнхөө дата бааз дээр боловсруулаад онооны системээ өгөх юм. Тэгээд бас хэд хэдэн зүйл Монголд илэрсэн юм.

Жишээлбэл, онооны систем гар утсаараа байнга шалгаад байхаар оноо нь буураад байдаг. Яагаад вэ гэвэл байгууллагууд чинь энэ эрсдэлтэй иргэн байна. Яахаараа заавал онооны систем шалгаад байдаг юм байнга байнга гээд. Яс юман дээрээ бол үндсэндээ сонирхоод л шинэ бүтээгдэхүүн юм чинь ороод байгаа шүү дээ. Тэгэхээр үүн дээр Монголбанк анхаарч ажиллаж бас журамдаа, баталж байгаа журамдаа илүү өөрчлөлт оруулаад Монгол Улсын нутагт илүү хөрсөн дээр буусан юм хийнэ гэж бодож байгаа.

Тэтгэврийн зээл бол үнэхээр бухимдуулж байгаа асуудлын нэг болчихсон юм сүүлийн үед. Ялангуяа энэ өр, орлогын харьцааг өөрчилснөөс болоод. Үүнтэй холбоотойгоор бас Монголбанк сая хэлж байна тодорхой хэмжээний өөрчлөлт оруулна гээд.

Ер нь тэтгэврийн зээлийг харахад бол бусад улс, орнуудтай харьцуулахад бол арилжааны чанарын зээлээс илүү бага байдаг юм байна лээ. Бразил, Энэтхэг, Өмнөд Африк, Кени, Филиппин, Гана гээд яг Монголтой адилхан тэтгэврийн системтэй улс орнуудын судалгааг харахад бол арилжааны зээлээс тэтгэврийн зээл нь 2-13 хувиар илүү бага хүүтэй байдаг.

Яагаад гэвэл энэ нь бол эрсдэл багатай зээл гэж хардаг. Нэг ёсны Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас сар болгон ямар өдөр тодорхой хэмжээний мөнгө нь дансанд нь орж ирэх нь гэдэг нь маш тодорхой байдаг. Тэрийг банкнууд нь

автоматаар суутгаад авчихдаг болохоор. Энэ утгаараа праймерит гэсэн бүтээгдэхүүн Монголбанк бас зах зээлд нэвтрүүлэх нь зөв гэж харж байгаа юм. Бид нар чинь бас 2 шатлалтай банкны системдээ шилжээд 35 жил болж байна. Тодорхой хэмжээний нэмэлт бүтээгдэхүүнээ гаргах нь зөв өө гэж харж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Иргэд болон аж ахуйн нэгж байгууллагаас санхүүгийн бас эрх чөлөөг нь тавьж өгөх энэ хуулийн төслийг дэмжиж байгаа Батшугар гишүүний санаачилсан. Түрүүн бас гишүүд хэллээ. Би бас дахиад давтаад хэлье. Ер нь энэ тэтгэвэр, цалингийн зээл чинь эргэн төлөлт нь хамгийн сайн бараг эрсдэлгүй шахам ийм зээл. Тийм учраас хүү нь илүү бага байх ёстой. Зээлийн эрсдэлийн сангийн зардал хамгийн бага. Гэтэл эсрэгээрээ сүүлд бодлогын хүү нэмэгдсэнтэй зэрэгцээд тэтгэврийн зээл 18 хувь болсон байна лээ.

Нэгдүгээрт хүү нэмэгдсэн.

Хоёрдугаарт олгох хугацаа нь хасагдсан.

Гуравдугаарт нийт тэтгэвэр авагчдын 80 хувь нь үндсэндээ 7, 800 орчим мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа. Тэрний өр, орлогынх нь харьцааг аваад үзсэн 700 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүн 500 мянган төгрөгийн амьжиргааны баталгаажих доод түвшнийг хасахаар цаана нь 200 мянган төгрөгт л зээл авах болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр нэг талдаа ахмадуудын тэтгэвэр ийм бага байгаа нөхцөлд нь дээр нь нэмж чангалж байгаа юм шиг аваачаад тэр зээл авах эрхийг нь 70 хувьд нь бараг хасаад хаячихаж байгаа юм. Тэгээд энэ чинь нийт тэтгэвэр авагчдын бараг 70 хувьд нь санхүүгийнх нь хэвийн явж байсан ийм зүйлд нь гэнэтийн ийм шийдвэрийг Монголбанкны манай Мөнгөний бодлогын хорооны гишүүд маань гаргачихдаг. Тийм учраас энэ бодит ажил, амьдрал дээр холбоотой би 2 тоо асуугаадахъя.

Ахмадуудын аав, ээжийнхээ тэтгэврийг аваад машин авчихдаг, үрээд хаячихдаг хэдэн хүн байдаг юм? Тийм судалгаа та нарт байдаг юм уу? Эргээд тэр хүнийг тэтгэврээрээ ажил амьдралаа залгахыг нь ингээд эрсдэлд оруулчихсан хэчнээн хүн байдаг юм? Би ийм хариуцлагатай шийдвэрийг нэлээн бодож байж гаргасан болов уу гэж бодож байгаа юм. Энэ тоог асуучихъя.

Хоёрдугаарт Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл гээд 700 орчим тэрбум төгрөгийг саяхан банкнууд байршуулж байгаа. Тийм учраас энэ чөлөөт үлдэгдлийг банкнууд байршуулж байгаа нөхцөлд зөрүүлээд тодорхой хувийг нь би бол дор хаяж 50-аас доошгүй хувийг нь энэ тэтгэврийн зээлийн эх үүсвэрт зарцуулаад дээр нь 2 хувийн марж ч юм уу, түүнээс бага хэмжээний марж нэмээд гэдэг юм уу ийм эх үүсвэрээр тэтгэврийн зээлээ нэмэх ийм зохицуулалтыг хийж болдоггүй юм уу гэж?

Гуравдугаарт энэ зээлийн хүүтэй холбоотой ярихад КОВИД-оос хойш аж ахуйн нэгж байгууллага болгон иргэдийн дансны чөлөөт үлдэгдэлд хүү тооцохгүй байж байгаад саяхан тооцсон байна. Ингээд арилжааны банкнуудыг харахаар тэрбумаас дээш дансны үлдэгдэлтэй хүү нь арай өндөр, 100 саяас доош 5, 10 сая төгрөгийн дансны чөлөөт үлдэгдэлтэй хүмүүст огт хүү тооцохгүй гээд хүмүүсийг

цалин, орлогынх нь хэмжээгээр нь хүүгийн ялгаварлалд ингэж хийж байгаа чинь Үндсэн хуулийн зөрчил мөн үү, биш үү? Өөрөөр хэлбэл илүү их мөнгөтэй хүмүүсийнх нь мөнгөнд хүүд тооцно. Багахан 5, 10 сая төгрөгийн дансандаа чөлөөт үлдэгдэлтэй байж байдаг хүмүүсийн чөлөөлөлт үлдэгдэлд хүүд тооцохгүй гэдэг ийм байдлаар наад арилжааны банкнууд чинь яваад байгаа юм. Тэгээд бид нар гаднын банк оруулж ирэхгүй, хямд эх үүсвэртэй юу оруулж ирэхгүй гээд л үндэснийхээ банкнуудыг хамгаалаад байна гээд байсан. Гэтэл энэ банкнуудын чинь яг хувь эзэмшигч нь хэд нь гадаадын хүн байдаг юм, гадаадын эх үүсвэрүүд байдаг юм? Иийм асуултуудыг асууя.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуултад хариулъя. Дараа нь Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч.

Э.Батшугар: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Энэ тэтгэврийн зээлийн асуудал маш чухал асуудал юм л даа. Маш олон ахмадууд сүүлийн үед гомдол бичиж байгаагаа, илэрхийлж байгаа. Тэгэхээр тодорхой хэмжээгээр бас чөлөөлөх нь зүйтэй л гэж харж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор нэг зүйлийг хэлэхэд бол ахмадуудын зээл нь өөрөө орлого нь маш тодорхой, эргэн төлөлтийг нь нэг ёсны автоматаар банк бус суутгаад авчихдаг. Тэгэхээр энэ эргэн төлөлт нь цаг хугацаандаа яваад байгаа юм чинь оноо нь өөрөө нэмэгдээд явчихна. Тэгэхээр цаашдаа бас илүү санхүүгийн үйлчилгээ авах таатай нөхцөл бүрдэж байгаа юм. Энэ онооны систем дээр шилжсэнээр.

Хоёрт нь бол бас та хэлж байна. Энэ ахмадуудын зээл бол хамгийн чанартай зээлүүдийн нэгд ордог. Эх үүсвэр нь маш тодорхой байдаг. Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас сар болгон аль өдөр хэдэн төгрөг орох нь маш тодорхой. Тэгэхээр илүү эрсдэл багатай зээлийн ангилалд ороод тэгээд хүү нь буурах ёстой гэсэн тийм байр суурьтай байна. Тэгээд үүнтэй холбоотойгоор би бас бусад улс орнуудын судалгааг товчхон танд танилцуулъя. Нэгд Бразил, Энэтхэг, Өмнөд Африк, Кени, Филиппин, Гана гэсэн тэтгэврийн систем нь яг Монголтой адилхан системтэй улс орнууд. Тэтгэврийн зээлийн бүтээгдэхүүн тухайн улс орнуудад бас байдаг. Энэ нь бол арилжааны чанартай зээлээс 2-13 хувийн бага хүүтэй зээл юм билээ.

Тэгэхээр нэг ёсны эрсдэл багатай, эх үүсвэр нь тодорхой зээлд илүү бага хүү авах нь илүү шударга юм л гэж хэлмээр байна л даа.

Гаднын банкнууд Монгол Улсад орж ирэхгүй байгаа гэж шүүмжлэл их ярьдаг л даа. Энэ нь бол хэд хэдэн зүйлтэй холбоотойгоор.

Нэгдүгээрт бол саяхан бас интернэтээр яваад байсан Уоррен Баффет Монгол Улсын хөрөнгө оруулалтын талаар ярьсан. Тэгэхэд бол төгрөгийн тогтвортой байдал нь хамгийн чухал гээд. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор манай банканд нэг үйлчилгээ дутаад байгаа юм. Тэр нь хедж/hedge/ гэж ярьдаг. Нэг ёсны валютын ханшийн эрсдэлийг хамгаалсан тийм бүтээгдэхүүн манайд байдаггүй юм. Энийг бол бас үүсэх ёстой гэж харж байгаа юм. Үүнтэй Монголбанк ч гэсэн олон жил ажиллаж байгаа. Тэгэхдээ ямар байдал, ямар зарчмаар үүсгэх нь гэдэг тодорхой бус. Яагаад гэвэл манай Монгол Улсад орж ирдэг валютын урсгал нь бол үнэхээр нүүрснээс хамааралтай, зэсээс хамааралтай байдаг. Харин гадаадын хөрөнгө оруулалт эрх маш бага хэмжээгээр орж ирдэг. Нэг ёсны дотоодын

бүтээгдэхүүний 12 хувьд нь л гадаадын хөрөнгө оруулалт байдаг. Хөгжиж байгаа улс орнууд бол энэ 40-60 хувь байдаг юм. Энэ 12 хувийн, 10 хувь нь бараг л Оюу толгой дангаараа эзэлдэг байдаг. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэх бас эрх зүйн орчныг бас сайжруулах нь үүгээр илэрхийлж байгаа юм гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Энхтайван Дэд ерөнхийлөгч ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Сүүлийн асуултаас нь эхлээд явчихъя. Гишүүн тэр харилцах дансны хүүтэй холбоотой асуудал хөндөөд байх шиг байна. Харилцах дансны үлдэгдэлд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн сайдын хамтарсан тушаалаар хүүгийн, харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг тогтоодог. Одоогийн байдлаар 3 хүртэл хувийн хүүг тооцож байгаа.

Харилцах дансны үлдэгдлийн хүү гэдэг маань тухайн иргэн, аж ахуйн нэгж өөрийнхөө урсгал зардал, урсгал гүйлгээг санхүүжүүлэх зориулалттай данс. Тэгэхээр энэ олон улсын жишгийн дагуу ч гэсэн харилцах дансны хүүг өндөр байх тийм зохицуулалт ерөөсөө байдаггүй. Хадгаламжийнхаа хүүтэй харьцуулбал. Манай орны хувьд харилцах дансны хүүг 3 хувиар тааз тавиад тогтоож байгаа нь олон улсын жишгийн хувьд ч тэр, одоо байгаа эдийн засгийн суурь нөхцөл байдлын хувьд ч бас харьцангуй өндөр, уян хатан ийм зохицуулалт байгаад байгаа юм.

Тэр гадаадын банктай холбоотой асуудал дээр төв банк бол нээлттэй байгаа. Гадаадын банкнаас Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлье гэсэн хүсэлт.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхийдөө ихэнх асуулт давхацлаа. Гэхдээ энэ скорин/scoring/ буюу онооны систем шилжүүлж байгаагаа дэмжиж байна. Гэхдээ хар жагсаалт, оноо муу байх 2, оноо доогуур байх 2 хэр их ялгаатай болох юм бэ? Тэгэхээр оноонд муу байгаад л, муу оноотой яваад байгаа хүмүүс нь хар жагсаалтад яваад байгаагаас бас юугаараа нарийн ялгаатай юм бэ? Тэгээд тэр муу оноотой байгаа хүмүүс оноогоо сайжруулахын тулд ямар боломж, бололцоог нь олгож байгаа юм болоо гэдэг ийм асуулт.

Энэ дээр холбогдуулж манайхан ер нь Монголын энэ зээл авч байгаа зээлдэгчдийн гэх юм уу ер, орлогын хувь рэйшио/ratio/ буюу хувь ялангуяа энэ тэтгэврийн зээл дээр хэд байгаа юм бэ? Тэгээд яагаад энэ тэтгэвэр авагчдад олгох зээлийг ингэж зогсоож байгаа, эс үгүй бол хувийг нь багасгаж байгаа юм? Үүний цаад шалтгааныг нь хэлээд өгөөч. Хувь нь ер нь хэд байгаа юм гээд.

Ер нь Монгол Улс чинь ядуурлын шугам нь 418 мянган төгрөгөөр тогтоочихсон байгаад байгаа юм. Тэгээд энэ 418 мянган төгрөгийг 15 хувиар буюу 64 мянган төгрөгөөр нэмэхэд л Монгол Улсын ядуурлын түвшин 10 хувиар нэмэгдэх гэж байна. Бараг 28 хувь гэдэг чинь 37.4 хувь руу орох гэж байгаа юм ядуурлын түвшин. Тэгэхээр энэ ядуурлын түвшин ийм өндөр байх магадлал асар өндөр байгаа нөхцөлд энэ зээл, энэ эрсдэл хэвээрээ л байх. Тэгэхээр зээлийн хүү

буурна гэж асуух гэж байсан чинь зөндөө хариулт өглөө. Гэхдээ мэдээж энэ тийм механикаар буурахгүй л байх макро эдийн засгийн үзүүлэлт, төсвийн тогтвортой байдал, Засгийн газрын зардал гээд л энэ бүх зүйлтэйгээ уялдаж л мэдээж буух байх л даа. Бодлогын хүү ийм өндөр байхад мэдээж хадгаламжийн хүү өсөж л таарна, зээлийн хүү өсөж л таарна гээд.

Энэ ер нь бид нар удахгүй төсөв хэлэлцэнэ. Тэгэхээр тэр төсөв хэлэлцэх энэ тэртэй энэ өнөөдрийн яриад байгаа энэ юмаа давхар бодож хэлэлцэхгүй бол бид нар мянга өнөөдөр зээлийн хүү яаж буурах юм гэж асуугаад ер нь хариулт нь хэцүү л байх гэж бодож байна. Тэр ер нь өр, орлогын хэмжээг хэлээд өгөөч ээ. Тэгээд тэр скорин/scoring/ систем буюу тэр хар жагсаалт, бага оноотой иргэдийн ялгаа юу болж хувирах болоо? Энэ дээр хэлнэ үү.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуултад хариулъя.

Э.Батшугар: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Одоо байгаа үйлчилж байгаа хууль болон тогтолцоо бол хар жагсаалт бид нар ярьдаг. Энэ нь шуудхан хэлэхэд бол тодорхой иргэн зээлийн доголдол үүсээд хэмжээнээсээ үл хамаараад эргэн төлсөн ч гэсэн 6 жилээр жагсаалт нь байдаг болохоор банк санхүүгийн байгууллагууд үүдээ хаачихдаг. Ямар ч тийм нэг ёсондоо санхүүгийн ял үүрээд байгаа юм 6 жилээр. Онооны системд шилжсэнээр бол хэрвээ тодорхой хэмжээгээр зээлийн доголдол үүсвэл оноо нь буурна. Зээлээ ахиж эргэн төлбөл буцаад өсөөд явчихна. Нэг ёсондоо 6 жилийн ял байхгүй гэж ойлгож болно хар жагсаалт. Тэгээд динамикаар бодит горимоор өсөөд, буураад л гэж явах тийм тогтолцоо руу явж байгаа.

Тэгэхээр нэг ёсны энэ бол илүү бодит амьдралыг илэрхийлсэн, мөн эрсдэлийг нь шууд илэрхийлээд үүгээрээ дамжаад хүү буурах бололцоотой л доо.

Өр, орлогын харьцаа бол Монголбанк илүү дэлгэрэнгүй хариулна байх. Гэхдээ хамгийн сүүлийн Мөнгөний бодлогын зөвлөлөөр бол 50:50 гэж тодорхойлсон. Харин санхүүгийн зохицуулалтаар бол 40:60 гэж явж байгаа. Өмнө нь 70:30 байсан юм.

Зээлийн хүүг механикаар бууруулах бололцоотой юу гэхээр бас хэцүү л дээ. Та яг зөв хэлж байна. Үндсэн суурь макро эдийн засгийн нөхцөл байдалтай хамааралтайгаар. Гэхдээ бид нар яг зээлийн хүү дээр дүн шинжилгээ хийхэд бол яг ийм тоо, үзүүлэлт харагдаж байгаа юм. Тэр нь бол яг зээлийн хүүг 18 байна уу, 17 хувь нь уу тэрийгээ 100 хувь гээд бодчихёе. Тэгвэл тэрний 67, 63 хувь нь бол эх үүсвэрийн зардал. Нэг ёсны шууд макро эдийн засаг, бодлогын хүү болон инфляцтай холбоотойгоор.

Харин эсрэгээрээ 15 хувь нь бол эрсдэлийн зардал гэж явдаг. Үлдсэн 22 хувь нь бол үйл ажиллагааны банкны зардал гэж явж байгаа юм. Урсгал зардал. Тэгэхээр бид нар энэ 15 хувь болон энэ 22 хувь дээрээ тодорхой хэмжээний тохируулга хийх бололцоог байгаа. Энэ скорин/scoring/ систем болон онооны систем рүү орсноор. Нэг ёсны өнөөдрийн үйлчилж байгаа нөхцөл байдал яаж эрсдэлээ бууруулах вэ гэвэл банкнууд харахад бол бүх зээлдэгч нарыг эрсдэлийг нь тодорхойлж чадахгүй болохоор энийг гэж хардаг. Тэгээд өндөр хүү тавьчихдаг. 15 хувийн хүү гэж яриад байгаа шүү дээ зардал. Тэр нь юутай холбоотой вэ гэхээр

магадгүй 5 хувь нь зээлээ төлөхгүй байж магад болно. Тэгвэл сайн төлөгчид дээрээ өндөр хүү аваад тэгээд тэр 5 хувийнхаа шархаа нөхнө гэсэн тийм нөхцөл яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр яг зээлдэгч нар тодорхойлдог болсноороо яг банкнууд оноогоор нь энэ хэр эрсдэлтэй зээлдэгч вэ хараад тэгээд үүгээрээ дамжуулаад нийт системийнхээ хүүгээ буулгах бололцоо нь үүсчхэж байгаа юм. Сайн зээлдэгч нь илүү таатай нөхцөлтэй зээл авна. Үнэхээр муу зээлдэгч нар бол арай өндөр хүүтэй зээл аваад ялгаатай явчихна.

Үйл ажиллагаа нь зардал ч гэсэн буурах бололцоотой болж байгаа юм. Яагаад гэвэл өнөөдөр зээл олгох гэж зээлийн эдийн засагчтай уулзаад тэгээд бараг 2 долоо хоног үйл ажиллагаа явдаг. Харин онооны системтэй болчихоор шууд өдөрт нь тэр зээлийн оноо нь тухайн иргэнийг илэрхийлдэг болохоор олгож бололцоо үүсэж байгаа.

Д.Амарбаясгалан: Энхтайван Дэд ерөнхийлөгч нэмж хариулъя.

Г.Энхтайван: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Банкнаас иргэдэд олгож байгаа болон хэрэглээ нөхцөлийг нь өөрчилж байгаа хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа 50 хувьтай байгаа. Тэтгэврийн зээл дээр тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн сарын төлбөрөө төлсний дараах зээлдэгчийн үлдэж байгаа орлого нь хүн амын амьжиргааны доод түвшнийг хангах хүрээнд хэмжээтэй байлгахаар хамгийн сүүлд зохицуулалт хийсэн байгаад байгаа.

Өр нь өр, орлогын харьцааг тухай бүрд нь Монголбанк зах зээлийн нөхцөл байдалтайгаа уялдуулаад тогтоогоод явдаг.

Зээлийн хүүтэй холбоотой асуудал дээр зээлийн хүү буурах хамгийн гол нөхцөл, хамгийн гол нөхцөл бол зээлийн эх үүсвэрийн хүртээмжийн асуудал байгаад байгаа. Арилжааны банкин дээр байгаа эх үүсвэр хүртээмж нь нэмэгдээд нэмэлтээр эх үүсвэр арилжааны банкин дээр орж ирсэн тохиолдолд зээлийн хүү буурах хамгийн бодитой арга зам нь тэр л байгаа. Түүнээс бусдаар зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, хэрэглэгчийг таньж мэдэх, зээлдэгчийн эрсдэлийг бууруулах гэх мэт.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Жудгийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Түрүүн Батшугар гишүүн өр, орлогын харьцаа 70:30 байгаад бараг 50:50 болсон гэсэн. Тэгэхээр энэ нь сайжирсан гэсэн үг байна шүү дээ ерөнхийдөө бол. Өрөнд төлдөг мөнгөн дүн буюу хувь нь багассан гэсэн үг байх шиг байна. Тэгэхээр энэ юу гэсэн үг юм бол? Зээл авагчдын тоо багассан гэсэн үг юм уу? Эсвэл юун дээр үндэслэж энэ тоо ингэж өөрчлөгдсөн юм?

Д.Амарбаясгалан: Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулт өгье.

Г.Энхтайван: Өр, орлогын харьцааны 50 хувь гэдэг маань тухайн зээлдэгчийн өөрийн сард олж байгаа орлогын 50 хувь нь зээл төлсний дараа өөрт нь үлдэнэ гэсэн зохицуулалт байгаа. 70:30 гэдэг маань урьд нь 70 хувьд нь зээл авч болно гэсэн байсан. Тэгэхээр энийг чангатгаж байгаа гэсэн үг буюу тухайн хэрэглэгчийн хэрэглээний зээлийн авах хэмжээ өөрийн орлогоос хамааран тодорхой хэмжээнд буурч байгаа гэсэн зохицуулалт байгаа.

Д.Амарбаясгалан: Тийм, Баярмаа гишүүн ерөнхийдөө энэ шийдвэрээр хэрэглээний зээл тодорхой хэмжээнд хумигдах нөхцөл рүү л орж байна гэсэн үг л болж байгаа юм байна лээ л дээ. Батшугар гишүүн нэг асуудал байгаа шүү дээ. Хуучин бол зээл авах гэж байгаа иргэн, аж ахуйн нэгж зээл түүний зээлийн мэдээллийг Монголбанкнаас шууд арилжааны банкнууд, банк бус санхүүгийн байгууллагуудад өгөгддөг байсан. Одоо болохоор энэ кредит скоринг/credit scoring/ тооцдог болоод ирэнгүүт 2 аж ахуйн нэгж тэр үйлчилгээг үзүүлж байгаа гэж байгаа юм. Тэгээд нэг асуудал ярьж байгаа нь зээлдүүлж байгаа банк зээлдэж байгаа аж ахуйн нэгж 2 тэр зээлийн мэдээллийг авсны төлбөрийг яагаад хувааж гаргаж болохгүй байна вэ? Яагаад ганцхан зээлдэгч тэр төлбөрийг төлдөг болчхов гэдэг асуудал хөндөгдөөд байгаа шүү дээ. Тийм биз дээ? Нэг нь зээл авч хэрэглэх гэж байгаа. Нөгөөдөх нь зээл өгч бизнес хийж байгаа шүү дээ. Тэгээд энэ 2 яагаад энэ төлбөр дээр харилцан ижил ачаа үүрэхгүй байгаа юм бэ? Энэ яах юм?

Батшугар гишүүн хариулъя.

Э.Батшугар: Амарбаясгалан дарга бас чухал асуудал ярилаа л даа. Энэ бол яг харилцагч болон банк 2 жигд тэгш харилцаатай байх ёстой. Аль нэг нь давуу тал үүсгэж болохгүй гэсэн л зүйл яригдаж байна л даа. Өнөөдрийн байдлаар бол бас банкнууд ч гэсэн энэ 2 компаниас юу авч байгаа лавлагаагаа авч байгаа. Мөн хэрэглэгч ч гэсэн бас авч байгаа. Гэхдээ нэг зүйлийг нь бас тодорхой хэлмээр байна. Энэ суурь үнэ нь байгаа юм 3000 төгрөг гээд. Нэг ёсны сая 600 мянган иргэн 3000 төгрөгөөр үржүүлэхээр чинь бараг 10 тэрбумын зах зээл үүсчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр яг үүнтэй холбоотойгоор энэ хуульд нэмэлт заалт орсон байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр Монголбанк үйлчилгээний хөлсийг тогтооно гэж. Нэг ёсны дээд таазанд тогтооно гэж заалт орсон. Энэ нь бас яг картын үйлчилгээний гүйлгээтэй холбоотой зүйл л дээ. Картын гүйлгээ гүйлгээг бол Монголбанк дээд хязгаар болон шимтгэлийн 1 хувийг тогтоосон байдаг. Аквайрын банк нь болон Мерчант банк нь 0.3 болон 0.7 хувиар хуваадаг.

Тэгэхээр Монголбанк бол санхүүгийн хэрэглэгчдийг хамгаалахын тулд яг дээд хязгаарыг нь тогтоож өгнө гэдэг чинь бас зөв гэж бодож байгаа юм. Яагаад гэвэл өнөөдөр 3000 байна, маргааш 30000 болохыг хэн ч хорьж чадахгүй байна. Нэг ёсны 2-хон компани хоорондоо бараг олигополь болчхоод хоорондоо үнээ тохирчих бололцоо нь байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр дээд хязгаарыг нь тогтооно.

Харин эсрэгээрээ банк хэрвээ зээлдэгч нь зээл авах гээд, үйлчилгээ авах гээд байгаа бол тэр скорингоосоо авч байгаа гэж ойлгож болно дарга. Мөн хувь хүн ч гэсэн хараад тэгээд бас тэр аппликэйшнээ өгч болно. Тэгэхдээ нэг ёсны Монголбанк бас журмаараа маш тодорхой зааж өгөх ёстой л доо. Хэрвээ тухайн иргэн банк болон банк бус байгууллагаас санхүүгийн байгууллагаас зээл авах гэж байгаа бол тухайн байгууллага нь үнэн, зөв мэдээлэл авахын тулд энэ бүрэн скор болон сайн скор болон 2 тусгай зөвшөөрөлтэй компаниасаа төлбөрийг нь төлөөд мэдээлэл нь авах ёстой. Иргэн сайн дураараа хэрвээ авъя гэвэл бас авах бололцоо нээлттэй байгаа. Тэгэхдээ үнэ хөлсний хувьд бол дээд хязгаарыг Монголбанк судалгааны үндэслэл дээр тогтоох нь зөв гэж харж байгаа юм. Тэгээд яг үүнтэй холбоотойгоор бас хуулийн заалт нэмэлт, өөрчлөлтөө оруулсан байгаа гэж танд хэлье.

Д.Амарбаясгалан: Сонин л болчихсон юм байна лээ шүү дээ. Хуучин Монголбанкиндаа энэ зээлийн мэдээллийг хариуцдаг байхдаа жилдээ 6 орчим тэрбум төгрөгийн төсөв гаргаж асуудлыг хариуцаад шийдээд явдаг байсан. Одоо хувийн 2 компани Кредит скорингийн компани үйл ажиллагаа явуулаад эхэлсэн жилийнх нь иргэдээс авч байгаа төлбөр нь 20 тэрбум хүрчихсэн байна гэж байна лээ шүү дээ. Тэгэхээр иргэд дээр л ахиад л дарамт аваачиж өгөөд байгаа байхгүй юу. Иргэдээс авдаг, аж ахуйн нэгжээс авдаг мөнгөө л нэмээд байна. Тэгсэн мөртөө талд нь арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд зээл өгч байгаа нэрээр баахан л мөнгө бизнес хийж байгаа шүү дээ. Тэгээд ийм шударга ёсны асуудал чинь яг л энэ мэт зүйлээс эхэлж байгаа шүү дээ. Тэгээд манай Монголбанк энэ дээр ер нь ямар бодлого барьж хэрэглэгчийн эрхийг хамгаалахад юу хийдэг юм бэ? Ер нь цаашдаа энэ санхүүгийн зах зээл дээрээс үйлчилгээ авч байгаа хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүрэг нь ганцхан Улсын Их Хуралд байх юм уу эсвэл энэ Монголбанк, СЗХ-ны дунд зээлдэгчийн эрхийг хамгаалдаг байгууллагатай болох ёстой юм уу? Энхтайван Ерөнхийлөгч энэ дээр хариулаадхаач.

Г.Энхтайван: Амарбаясгалан даргын асуултад хариулъя. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлж байгаа 2 аж ахуйн нэгж хэрэглэгчээс хураамж авч байгаа. Хураамжийнхаа хэмжээг тогтоогоод үндэслэлээ Монголбанкинд ирүүлдэг. Өнгөрсөн жилийн байдлаар 2 компани нийтдээ зах зээл дээр байгаагаас харахад 17 орчим тэрбум төгрөгийн борлуулалт аль аль компани нийлээд хийсэн байсан. Энэ нь харьцуулаад тооцоход өнгөрсөн жилүүдээс маш өндөр өссөн байгаад байгаа юм.

Зээлдэгчийн тэр төлж байгаа хураамжийг зээлдүүлэгч буюу банк санхүүгийн байгууллага, зээлдэгч буюу иргэн, аж ахуйн нэгж хоёулаа хувааж төлөх бол тэн дээр бүрэн боломжтой. Яг одоогийн нөхцөл байдлаар яаж явж байгаа вэ гэхээр тухайн үйлчилгээг хэн нь авч байгаа буюу зээлдэгч нь өөрөө хүсэлтээ гаргах юм бол тухайн байгууллага нь төлж байгаа. Зээлдүүлэгч нь хүсэлтээ гаргах юм бол төлж байгаа. Тэр борлуулалтын орлогын ингээд хувийг харахад 20 орчим хувийг нь тухайн зээлдүүлэгч нь буюу банк санхүүгийн байгууллага өөрөө хүсэлт гаргаад авч төлж байгаа. Үлдсэнийг нь зээлдүүлэгч нь төлсөн байгаад байгаа. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай асуудал бол манай энэ зах зээлийн гол асуудал. Хамгийн гол асуудал.

Тэгээд Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг өнгөрсөн 4 жилийн хугацаанд төв банкнаас боловсруулаад бас Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхэд бэлдээд явж байгаа.

Энэ дээр өргөн барих субъект нь тухайн үед өнгөрсөн 4 жилийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар дээр ажлын хэсэг нь гараад явж байгаа. Ер нь санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, тухайн хэрэглэгч санхүүгийн үйлчилгээ авахдаа өөрийн эрх ашгаа хэрхэн хамгаалуулах, ямар үйлчилгээг ямар үнэ хөлстэйгөөр хэрхэн, яаж авах, энэ үйлчилгээг авсныхаа төлөөс нь ямар төлбөр төлөх, эргээд хэрэглэгчийн эрх ашгаа хэрхэн хамгаалуулах тухай бодитой тийм зохицуулалтуудыг энэ хэрэглэгчийн, Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль дээр бид бүхэн оруулаад явж байгаа.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль бол дэлхийн бусад бүх дийлэнх орнуудад байдаг. Тэгэхдээ Төв банк энэ санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг арилжааны банк болон бизнес эрхлэгч нар, Худалдаа аж үйлдвэрийн танхим хэрэглэгчидтэй хамтарсан тийм сургалт гэх юм уу, хэлэлцүүлгийг зохион байгуулсны үндсэн дээр энэ хуулийн драфтыг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Харин тийм яг л ийм л байгаа юм л даа. Хэрэглэгчийн зээлдэгчийн эрхийг ярихаар ингээд Монголбанк түгдчээд хариулж чадахгүй юм. Банкны эрх ашгийг яривал жигтэйхэн уулгахан хариулаад явчихна. Тэгэхээр энэ Монголбанк ч тэр, Санхүүгийн зохицуулах хороо ч тэр ер нь зөвхөн салбарын эрх ашгийг хангах гэж байдаг байгууллага гэж боддогоо болих хэрэгтэй. Өнөөдөр Монголчууд тэр аяараа банк санхүүгийн байгууллагын ажилтан болчихсон. Хөдөө малчид нь банкны мал малладаг болчихсон, хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагчид нь банкны мөнгийг богино хугацаанд өндөр хүүгээр өсгөж өгдөг. Ажилчид нь болчихсон бизнесийн байгууллагууд нь өндөр хүүтэй зээлийн дарамтаас гарч чадахгүй бизнесээ өргөжүүлж чадахгүй тэр нөхцөлд он удаан жил үргэлжилж байгаа нөхцөл л байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хэрэглэгчийн эрх, зээлдэгчийн эрх, санхүүгийн зах зээл дээр үйлчилгээ авсан хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал гэдэг өөрөө чухал байна Энхтайван Ерөнхийлөгч өө. Монгол Улсын Их Хурал яагаад хүн төвтэй хууль, эрх зүйн орчныг бий болгоно гэдэг стратеги хэрэгжүүлэх гэж 3 төгөлдөршил-ийн бодлого хэрэгжүүлж байгаагийн шалтгаан ердөө энэ байгаа юм. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо Сэддорж дарга энэ зээлдэгч, санхүүгийн үйлчилгээ авч байгаа хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, энэ эрхийг хамгаалдаг бүтэц ямар хэлбэрээр явах ёстой талаар Байнгын хороо энэ тэр богино цаг хугацаанд идэвхтэй ажиллаад ер нь Улсын Их Хуралд танилцуулах хэмжээнд бэлтгэх нь зүйтэй гэж бодож байна. Өнөөдөр ерөөсөө л энэ зээлдэгчийн эрхийн асуудал хамгийн тулгамдсан асуудал болчихсон.

Ерөөсөө өгдөг арилжааны санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын олгодог зээлийн сонирхол нь богино хугацааны өндөр хүүтэй хэрэглээний зээл болчихсон. Бизнесийн зээл, хөрөнгө оруулалтын зээл дээр анхаарал хандуулдаггүй. Зарим том банкнуудын нийт үзүүлж байгаа үйлчилгээ зээлийнх нь 70 хувь нь хэрэглээний зээл болоод хувирчихсан. Тэгээд л зээлээс зээлийн хооронд зээлийн дарамт дунд нийгэм тэр чигээрээ явж байна. Төр нь ч гэсэн тэр дарамтад орчихсон. Тэгэхээр энэ асуудал дээр онцгой анхаарч ажиллая Сэддорж дарга энэ дээр анхаараарай.

Энхбатын, Жудгийн Баярмаа гишүүн дахин тодруулж асууя.

Ж.Баярмаа: Би уг нь маш тодорхой л асуусан юм л даа. Өр, орлогын харьцаа хэд байсан бэ ахмадуудын хувьд? Тэгээд маш хүнд байгаа учраас тэр хувийг нь бууруулж байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр бараг 90 хувь байсан юм биш үү? Өр, орлогын харьцаа гэдэг чинь олж байгаа орлогынхоо бараг 80, 90 хувийг нь тэр чигтээ өрөндөө өгөөд үлдэж байгаа нь 10, 20-хон хувь байна л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр 90 рүү дөхөж ирсэн учир бараг 70 болгож бууруулаад байгаа юм уу гэсэн ийм асуулт. Тэгээд сая өндөр хөгжилтэй улс 30:70 ч юм уу эсрэгээрээ, түрүүн яг Батшугар гишүүн зөв хэллээ л дээ 70:30 буюу нийт орлогынхоо 70 хувийг нь өрөнд өгөөд 30 хувь нь л хэрэглээндээ үлдэж байна гэдэг

энэ. Энэ өр, орлогын харьцаа яг хэд байгаа юм бэ? Нийт иргэдийн хувьд, тэтгэвэр олгогчид, тэтгэвэр авагчдын хувьд? Хэдэн хувь нь маш хүнд буюу бараг 80, 90 хувиа өрөнд өгөөд байгаа юм бэ гэдэг энэ статистик тоог л уг нь асуугаад байгаа юм л даа. Маш тодорхой.

Д.Амарбаясгалан: Энхтайван хариулт өгье.

Г.Энхтайван: Яг олгогдож байгаа нь би түрүүн хэлсэн арилжааны банкнаас хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 50:50 хувиар тогтоосон. Өмнө нь 60:40 байсан. 60:40 гэдэг маань тухайн зээлдэгчийн зээлийн төлбөр нь нийт орлогынх нь хувиас хэтрэхгүй байна гэсэн үг. 40 хувь нь үлдэж байна гэсэн үг. Энийг чангаруулаад 50:50 болгосон гэсэн үг. Тэтгэврийн зээл чинь өмнө нь хэрэглээний зээлийн нэг хэсэг учраас яг энэ дүрмээ мөрдөөд яг энэ хязгаарлалтдаа байсан гэсэн үг.

Тэтгэврийн зээлийг одоо болохоор амьжиргааны доод түвшнээс үлдэж байгаа хэсэг нь багагүй байхаар зохицуулалтыг оруулсан гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Батшугар гишүүний өргөн барьсан энэ нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа. Зорилго нь хар жагсаалтыг үгүй болгож, иргэдэд энэ зээлийн дарамтыг бууруулах, хүүгээс гадна яг бодит өөрийнхөө нөхцөл байдалтай таарсан хүүтэй ийм санхүүгийн хэрэгсэлд авах ийм боломжийг нээж байгаа. Энэ дээр би нэг зүйлийг өнөөдөр бид хийж чадахгүй байгаа ч гэсэн энэ Монголбанкны оролцоо энэ дээр хэтэрхий их байгаа гэдгийг хэлмээр байгаа юм. Монголбанкны үндсэн үүрэг бол ерөөсөө үндсэн мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдал, энэ инфляцаа барих, тэгээд системийн энэ эрсдэлийг барих. Тэрнээс биш иргэдийн зээлд ингэж ороод байх нь өөрийнх нь үндсэн ажил нь огтоос огт биш. Тэгэхээр Санхүүгийн зохицуулах хороо магадгүй энэ цаашид энэ тусгай зөвшөөрлийг нь өгөх, энийг хянах энэ ажлууд дээрээ нийт бусад санхүүгийн хэрэгслүүд банк бус санхүүгийн байгууллагуудын зээлүүд, мөн даатгал гэх мэтчилэн энэ бусад салбарууддаа оруулах ёстой гэж бодож байгаа юм.

Гэхдээ өнөөдөр энэ хууль дээр Монголбанк энэ тусгай зөвшөөрлөө өгнө. Монголбанк мөн энэ онооных нь ерөнхий аргачлалыг батална гэж оруулсан байгаа. Гэхдээ цаашдаа сая Улсын Их Хурлын даргын хэлсэн энэ санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах агентлаг юм уу бүтэц бий бол тийшээгээ шилжиж олон улсын жишигт нийцэх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Миний энэ хууль санаачлагчаас болон Монголбанкнаас асуух 2 асуулт байгаа.

Эхнийх нь юу вэ гэхээр одоо энэ хар жагсаалт гээд байгаа муу зээлийн түүхтэй иргэдэд одоогийн системийн банкнууд зээл өгөх боломжтой биз дээ? Одоо хорьсон зүйл огт байхгүй байгаа. Тэгэхээр жишээлбэл муу зээлийн түүхтэй ч гэсэн Хаан банкин дээр ч юм уу, Голомт банкин дээр очоод тухайн зээлийн түүхэндээ таарсан скорингтой ч бай, скоринггүй ч бай тухайн зээлийн түүхэндээ таарсан зээлийг эргэн авах боломжтой юу? Энэ дээр Монголбанк ажиллаж байгаа юу? Энэ системийн банкнуудтайгаа эдгээр хар жагсаалтын түүхтэй байгаа иргэддээ энэ зээлүүдийг нь нээх дээр нь одоо зохицуулалт нь ямар байгаа вэ гэдэг эхний асуулт байна.

Хоёр дахь асуулт нь хувь хүний мэдээлэлтэй холбоотой. Би ингээд E-Mongolia руу ороод өөрийн зээлийн скорингийг харъя гэж байгаа. Одоо тусгай зөвшөөрөл эзэмшсэн 2 байгууллага байна гэж сая хууль санаачлагч бас хэлж байна. Сайн скор/Sainscore/, Бүрэн скор/Burenscore/ гээд ингээд 2 байгууллага. Эндээс би зээлийн скорингийн оноогоо авъя гэхэд 1000 төгрөг төлж байгаа юм. 1000 төгрөг төлөөд аль нэгийг нь сонгоод ингээд оноо гэдэг зүйл нь гарч ирэх нь ерөөсөө л зээлийн түүх гэдэг л юм гарч ирж байгаа юм. Ямар ч нэмэлт боловсруулалт байхгүй зүгээр ийм мэдээллийг дамжуулж байгаа шууданчийн ажил шиг л юм хийж байгаа юм. Тэгээд миний гайхаад байгаа юм нь яагаад энэ Сайн скор/Sainscore/, Бүрэн скор/Burenscore/ гэдэг 2 байгууллагад миний санхүүгийн мэдээллийн түүх байна вэ? Би энэ хоёрт санхүүгийн мэдээллээ өгье гэдгийг зөвшөөрөөгүй байхад. Тэгвэл өнөөдөр Монгол Улсын бүх иргэдийн санхүүгийн мэдээллийн түүх энэ 2 байгууллагад байгаа юм уу? Тусгай зөвшөөрөл авсан гээд бүх иргэдийн зээлийн түүхийг энэ скорин компаниуд авч байгаа юм уу? Тэгэхээр иргэний зөвшөөрөлгүйгээр би ерөөсөө 1 кноп дараад л тэр мэдээлэл нь гарч ирж байна гэхээр энэ хоёрт аль хэдийн мэдээлэл байгаа байхгүй юу. Иргэдийн зөвшөөрөлгүйгээр энэ санхүүгийн мэдээллийг өгч байгаа дээр ямар хяналт байна? Энэ ямар хуулийн зохицуулалттай вэ гэдгийг бас өнөөдөр Монголбанкны Хуулийн хэлтсийн хүн ирсэн байгааг нь бас олзуурхаж онцгойлон энийг асууя. Тэгээд хариултаас нь шалтгаалж нэмж асууя.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн хариулт өгье.

Э.Батшугар: Тэгээд байгаа хар жагсаалтад орчихсон байгаа иргэн бол нэг ёсондоо тэр жагсаалт 6 жилээр хадгалагдаад байгаа юм. Тэгээд зээлээ иргэн төлсөн ч гэсэн 6 жил нь байж л байна. Харин онооны системд орсноор хар жагсаалт гэсэн зүйл байхгүй болно.

Д.Амарбаясгалан: Батшугар гишүүний микрофоныг өгье.

Э.Батшугар: Хар жагсаалт гэж зүйл байхгүй болно. Хар жагсаалт гэдэг чинь нэг ёсны санхүүгийн ял шүү дээ. Тэгээд 50 мянган төгрөгийн 5 мянган төгрөгийн ялгаа байхгүй тодорхой хэмжээнд доголдол үүсэхээр мэдээлэл нь 6 жилээр хадгалагдаад тэгээд санхүүгийн ял нь 6 жилээр байж байдаг.

Харин онооны системдээ орсноор бол хэрвээ зээлээ эргэн төлчихвөл оноо нь нэмэгдээд явчихна. Нэг ёсны хар жагсаалт зүйл байхгүй болно. Харин илүү динамик бодит горимоор оноо руу орж байгаа юм. Тэгэхээр тухайн иргэн илүү санхүүгийн сахилга баттай болсноор оноо нь нэмэгдэх бололцоо нь үүсгэж байгаа байхгүй юу. Гол зөрүү нь бол 6 жил хар жагсаалт нь хадгалдаг зүйл байхгүй болоод бодит горимоор оноо нь нэмэгдэх тийм боломж үүсэж байгаа гэж ойлгож болох юм аа? Яах вэ түрүүн Болормаа гишүүн хэлж байна яг санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах субъект өнөөдөр байхгүй байна гэж, мөн Их Хурлын дарга ч гэсэн хэлж байна. Бусад хөгжсөн улс орнууд бол бүгдэд нь л байдаг юм байна. Тэгээд тухайн байгууллага нь яг энэ онооны систем болон кредит скорын үйлчилгээ өгдөг байгууллагуудыг хянадаг. Нэг ёсны Америкт бол Консумер Файнаншип продакшн/Consumer Financial Production/ буюу Канадад бол Файнаншип Консюмер, Эженси оф Канад/fFinancial Consumer Agency of Canada/, Япон бол Файнаншип Сервис, Эженси /Financial Services Agency/ гээд тийм

субъект байгаад байдаг. Институт байдаг. Монголд одоо байхгүй байгаа. Ганц зүйл нь бол Төв банкны тухай хуульдаа Төв банк санхүү хэрэглэгчийн эрхийг хамгаал гэсэн тийм заалт байдаг. Цаашлаад юм байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр яг ийм институт болон байгууллага үнэхээр байгуулагдаад ёстой цаг нь болчихсон гэж ойлгож болно.

Харин бусад 1.7 сая иргэний мэдээлэл ямар байдлаар авсан, ямар эрх зүйн орчноос тухайн 2 байгууллага нь авчхаад боловсруулаад байна гэдэг зүйлийг бол Монголбанкнаас илүү дэлгэрэнгүй хариулна байх.

Д.Амарбаясгалан: Уг асуудлыг хэлэлцэх Дэгийн тухай хуулиар заасан хугацаа дууссан. Тэгэхээр 2 гишүүн асуулт асуухаар бүртгэгдсэн байгаа учраас асуулгаад асуудлыг хэлэлцээд дуусъя гэж ингэж бодож байна.

Энхтайван Дэд ерөнхийлөгч нэмж хариулт өгье.

Г.Энхтайван: Болормаа гишүүний асуултад хариулъя. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 5.1.2 дээр тухайн зээлдэгч өөрийн мэдээллийг санд нийлүүлэх зөвшөөрлөө өгч байгаа буюу тухайн зээлдэгчийн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр л мэдээллийг нь нийлүүлэхгүй байгаа гэсэн үг. Таны мэдээлэл санд орсон бол та тухайн зээлийг авахдаа зээлийн гэрээн дээрээ зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх зөвшөөрлөө гэрээгээрээ өгсөн байна л гэсэн үг.

Гэрээгээр өгөгдөөгүй тохиолдолд мэдээлэл нийлүүлэгдэхгүй байгаа. Төв банкны тухай хууль дээр санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндсэн функц байгаа. Энэ функцийг ажиллуулах хүрээнд төв банкнаас санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, тухайн санхүүгийн үйлчилгээ авсныхаа хүрээнд эрхээ хэрхэн хамгаалуулахад нь хяналт тавих үндсэн чиг үүргийн дагуу Төв банкнаас энэ зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 2 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хуулийн дагуу хяналтыг тавьж байгаа, зохицуулалтыг хийж байгаа. Улирал бүрд шалгалт хийдэг, үйл ажиллагаанд нь бүрэн хяналтыг тавьж.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн тодруулж асууя.

Э.Болормаа: Батшугар гишүүн сая хэллээ л дээ хар жагсаалт гэдэг зүйл ер нь байхгүй болно гэж. Яг энэ орж байгаа өөрчлөлтүүд дээр надад яг энэ бүрэн хэрэгжих болов уу гэдэг ийм мэдрэмж төрөөд байна л даа. Яагаад гэвэл 5 жил мэдээллийг нь хадгална гэж бид нар энэ хуулийн өөрчлөлт оруулж байна. Тэгэхээр би Монголбанкнаас маш хариуцлагатайгаар асууя. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт хэрэгжсэнээр хар жагсаалт гэдэг зүйл яг байхгүй болох уу? Монголбанкнаас яг асуух нь зүйтэй байх. Яагаад гэвэл зорилго нь үгүй болгох гээд байгаа боловч яг энэ зүйл байхгүй болох уу гэдгийг Монголбанкнаас тодруулъя.

Хоёр дахь нь болохоор сая хэллээ л дээ. Зээл авсан хүн ингээд мэдээллийн санд мэдээллээ нэгтгэж байна. Би мэдээллийн санд мэдээллээ нэгтгэхийг зөвшөөрсөн байсан ч тэрийг би Бүрэн скор/Buren score/ энэ Сайн скор/Sain score/ 2-т нийлүүлнэ гэдгийг зөвшөөрөөгүй байгаа шүү дээ. Тэгэхээр Монгол Улсад бараг зээл аваагүй насанд хүрсэн хүн байхгүй байх. Тэгэхээр энэ бүх хүмүүсийн мэдээ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхтайван нэмж хариулъя.

Г.Энхтайван: Болормаа гишүүний асуултад нэмж хариулъя. Энэхүү хууль өргөн баригдаад батлагдсанаар нийт зээлдэгч нар бүгдээрээ санхүүгийн оноотой болно л гэсэн үг. Тухайн оноон дээрээ үндэслээд тухайн арилжааны банкнаас зээл авах эрх нь нээлттэй байна. Яг одоогийн байдлаар ангилал буураад зээлийн бид бүгдийн ярьдгаар муу зээлтэй болчихсон, хар жагсаалтад орчихсон гээд байгаа иргэд, аж ахуйн нэгж ч гэсэн арилжааны банкнаас зээл авах эрх нь нээлттэй байгаа. Зээл аваад явж байгаа. Зүгээр тухайн зээлдэгчийн авч байгаа зээлийн хэмжээ болон хүү хүртээмж дээр л тухайн зээлийн чанараас хамаарсан өөрчлөлтүүд орж байгаагаас биш санхүүгийн үйлчилгээ авах эрх нь нээлттэй байгаад байгаа юм. Ямар тохиолдолд үйлчилгээ авч чадахгүй байна гэхээр барьцаа хөрөнгөгүй буюу барьцаагүй аппликэйшний зээлүүд дээр энэ мэдээж бас харьцангуй хүндрэл учраад байгаа.

Гэхдээ энэ зээлийн оноо гэдэг маань түрүүн Батшугар гишүүн хэлсэн энэ бодит биет бус хөрөнгө юм. Тэгэхээр биет бус хөрөнгө нь сайн байх юм бол энийгээ барьцаалаад тухайн зээлийн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Сонгобайгийн Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Батшугар гишүүний энэ оруулж ирж байгаа хуулийг дэмжиж байна. Тэгэхдээ энэ Монголбанкнаас асуух юм байна. Зээл төлж дуусангуут хар жагсаалтаас гаргаж болдоггүй юм уу? Яагаад 5, 6 жил гээд хугацаа заагаад байгаа юм бэ нэгдүгээрт?

Хоёрдугаарт, малчдын зээл хамгийн өндөр хүүтэй, 20 хувийн хүүтэй байдаг юм байна. Үүний 2-3 хувь нь эрсдэлд авч байгаа юм байна шүү дээ. Тэгэхдээ малчид ямар байгалийн гамшигт өртөж, малаа алдаж, давагдашгүй хүчин зүйлд автаж байхад дээрээс нь банкны зээл эргэн төлөлт гээд дарамтлаад тэгээд маш хүнд байдалд оруулдаг. Энийг уян хатан болгох боломж байна уу?

Гуравдугаарт, ихэнх улс орнуудын Засгийн газар зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоож өгдөг юм байна. Манай улсад тийм зохицуулалт байгаа юу? Дараа нь Монголбанк гадаад худалдаа болон төлбөрийн тэнцэл, валютын нөөц дээрээ яаж ажиллахаа мэдэхгүй ханш их алдаж байна. Бусад улс орнууд валютын ханш буурч байхад Монгол Улсад валютын ханш нь өсөөд байдаг. Үүнд ямар арга хэмжээ авч байна? Дараа нь банкууд зээл олгоход заавал хураамж авдаг, дээрээс нь өндөр хүүтэй. Энийг зохицуулах боломж байдаг юм уу манай улсад? Тэтгэврийн зээлийн талаар сая хүмүүс бас давхардчихлаа. Тэгэхдээ би энийг бас нэмж хэлмээр байна. Тэтгэвэрт байгаа хүмүүс яагаад зээл авдаг вэ гэхээр өвлийн идэшний үед, хэрэгцээт үед зээл авдаг. Тэгэхээр 24 сараар авч байсан жилийн хугацаа хаачихсан байна? Дээрээс нь маш өндөр хүүтэй. Тэтгэврийн зээл хамгийн баталгаатай зээл шүү дээ тэр чинь. Тэгээд ийм өндөр хүүгээр олгож болж байгаа юм уу? Энэ асуулт дээр хариу авъя. Тодруулах юм байвал дараа нь тодруулна.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуултад хариулъя.

Э.Батшугар: Замира гишүүний асуултад хариулъя. Одоо байгаа хуулийн үйлчилж байгаа нөхцөл нь яг 6 жил гээд зачихсан байгаа юм. Тэгээд хар жагсаалтад орчхоод иргэн төлсөн ч гэсэн 6 жилдээ байгаад байдаг. Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлт нэмэлт орсноор, онооны систем рүү орсноор хар жагсаалт гэдэг зүйл байхгүй болно. Хэрвээ зээл нь тодорхой хэмжээнд доголдол үүсвэл оноо нь буурна, эргэж төлөхөөр буцаад үүсээд явчихна. Бодит горимоор. Одоо байгаа нь үйлчилж байгаа нөхцөл байдал бол хуулийн эрх зүйн байдалд бол хар жагсаалт орчхоод л тэр чигээрээ л 6 жил яваад байдаг. Тэр байхгүй болно гэж ойлгож болно.

Малчдын зээл бол тодорхой хэмжээнд малчдын мал нь индексжүүлсэн даатгалд байдаг. Үүнтэй холбоотойгоор сая хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой тогтоолын төсөл орж байгаа юм. Тэр нь бол нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зээлдэгч нь зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоох гээд. Нэг ёсны давагдашгүй хүчин зүйл болон бусад зүйлдээ хамаараад тухайн зээлдэгчийн орлого нь өөрөө тухайн зээлдэгчийн хамаарахгүйгээр доголдол үүсэх хаагдвал энэ зээлийн онооны систем нь илүү уян хатан үйлчилнэ гэсэн тийм агуулгатай тогтоол байгаа юм.

Тэтгэврийн зээл ч одоо нэг ёсны буурах л ёстой гэж хэлээд байгаа юм л даа зээлийн хүү нь. Яагаад гэвэл орлого нь тодорхой Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас сар болгон тэдэн төгрөг данстай орж ирэх нь маш тодорхой байдаг. Тэгэхээр автоматаар банкнууд суутгалаа авчихдаг. Тэгэхээр энэ эрсдэл багатай зээл гэж ангилж болно. Үүгээр үүнийг дагаад тэгээд илүү зээлийн хүү нь буурах нь зөв өө гэж хэлмээр байна.

Ханш төлбөрийн тэнцэл бол илүү Монголбанк хариулна байх. Тэгэхдээ бол үнэхээр өнөөдрийн нөхцөл байдалд бол нүүрсний үнэ буурсан, мөн өнгөрсөн онтой харьцуулаад гарч байгаа хэмжээ нь ч гэсэн тодорхой хэмжээгээр буурчихсан байгаа. Тэгэхээр Монгол Улсад орж ирж байгаа валютын урсгал өөрөө буураад, үүнтэй холбоотойгоор ханшийн төлбөрийн тэнцлийн дарамт ирж байгаа юм. Эсрэгээр импорт өөрөө нэмэгдсэн байгаа. Тэгэхээр зах зээлд долларын эрэлт нэмэгдээд хангаж чадах валют нь өөрөө хомсдолд ороод тэгээд Монголбанк 7 хоногт 2 удаа валютын дуудлага худалдаа хийдэг. Энэ хэмжээ нь өөрөө тодорхой хэмжээгээр эрэлтийг нь хангаж чадахгүйгээс болоод ханш өсөөд байгаа гэж бас та ойлгож болно. Тэгэхдээ үүнтэй илүү Монголбанк дэлгэрэнгүй мэдээлэлтэй тоотой хариулна байх.

Д.Амарбаясгалан: Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулъя.

Г.Энхтайван: Замира гишүүний асуултад хариулъя. Валютын ханшны тухайд валютын ханшийг тогтвортой барих урьдач нөхцөл нь төлбөрийн тэнцэл байдаг. Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар төлбөрийн тэнцэл 486 орчим сая долларын алдагдалтай гарсан. Тэгэхээр манай валютын ханш маань өөрөө манай улсад орж ирж байгаа гадаад валютын орох, гарах урсгалын тэнцвэр дээр тогтдог гэсэн үг. Тэгэхээр эхний улиралд төлбөрийн тэнцэл алдагдалтай гарсантай холбогдуулаад валютын ханш оны эхнээс бас 4.4 орчим хувиар сулраад байна.

Төв банкнаас валютын зах дээр огцом савлагаа үүсгэхгүйн үүднээс бодлогын зохицуулалтуудыг авч давтамжтайгаар зах зээл дээр валютыг

нийлүүлээд ажиллаж байгаа. Уян хатан зохицуулалттай байх боломжтой юу гээд асууж байна. Түрүүн гишүүн бас хэлчихлээ энэ малчны зээл дээр. Тухайн зээлдэгч маань өөрөө барьцаа хөрөнгөө малын индексжүүлсэн даатгалд даатгуулаад тэр хүрээндээ 2 хувийн зээлийн хүүгийн хөнгөлөлт аваад явж байгаа буюу тухайн барьц.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Энхтайван: Тухайн барьцаа хөрөнгө нь даатгалд хамрагдсан тохиолдолд Төрийн банк болон Хаан банкнаас зээл авахдаа зээлийн хүүн дээр нь 2 хувийн хөнгөлөлт авч байгаа. Монголбанкнаас нийгэм, байгаль, цаг уурын энэ хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас зээлээ төлөөгүй зээлийн ангилал буурсан тохиолдолд энэ зээлийн ангилал бууруулах зохицуулалтыг өнгөрсөн 2024 оны 3 дугаар сараас эхлэн тодорхой хугацаанд жил 8 сарын хугацаанд хойшлуулаад явсан байгаад байгаа. Тэгэхээр яг энэ зудаас шалтгаалаад малчид зээлээ төлөөгүй, зээлийн төлбөр хойшилсон тохиолдолд зээлийн ангилал өөрчлөгдөхгүй гэсэн тийм зохицуулалтыг өнгөрсөн оны 3 сараас арилжааны банкнуудад өгөөд бид нар зохицуулалт хийгээд явсан.

Ер нь арилжааны банкнаас зээл авч байгаа тохиолдолд тухайн зээлийн зээлээ ристракшн/retraction/ буюу зээлийн эргэн төлөлттэй нь өөрчлөлт оруулах эрх нь тухайн зээлдэгч болон банк 2-т харилцан тохиролцсоны үндсэн дээр бий болдог.

Д.Амарбаясгалан: Замира гишүүн тодруулж асууя.

С.Замира: Энэ ихэнх улс орнуудад энэ зээлийн хүүгийн тэтгэмжийг тогтоодог манай Засгийн газарт. Тэгээд манай улсад тийм зохицуулалт байна уу гэсэн хариу авч чадсангүй. Тэгээд банкнууд зээл олгоход заавал хураамж авдаг шүү дээ. Дээрээс нь өндөр хүүтэй. Ер нь энэ хураамж гэдэг юмыг зохицуулах боломж байдаггүй юм уу манай оронд? Ийм 2 асуудал.

Д.Амарбаясгалан: Энхтайван.

Г.Энхтайван: Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох тухай Замира гишүүн хөндлөө. Яг ийм зохицуулалттай улс орнуудад байдаг мөнгө хүүлэлтийн тухай хуультай улс орнууд ч байдаг. Тэгэхдээ Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль дээр зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох тийм зохицуулалтуудыг бид бүхэн хуулийн драфт дээр нь оруулаад ажиллаад явж байсан. Ер нь энэ дээр бас бүүр юу гэдэг юм энэ дээр хатуу, энэ болно, болохгүй гэсэн тийм бодол байдаггүй. Яг хувь хүнийхээ хувьд хэлэхэд бас энэ дээр зээлийн хүүгийн дээд хязгаар дээр зохицуулалт хийх боломжтой гэж байгаа. Одоо мөрдөгдөж байгаа Мөнгөн зээллэгийн тухай хууль дээр СЗХ-ны зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоогоод явж байгаа.

Хураамж, шимтгэлтэй холбоотой руу Банк эрх бүхий этгээдийн мөнгөн зээллэг, хадгаламжийн тухай хууль дээр тухайн санхүүгийн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө авах шимтгэл, хураамжийг тухайн зээлд үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрөө тогтооно. Тогтоосон шимтгэлийнхээ хэмжээг зохицуулагч байгууллагад мэдээлнэ гэсэн тийм зохицуулалт байгаа. Энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Өнөөдөр бас бага ч гэсэн жоохон бас бодлогын хүүг, зээлийн хүүг бууруулах талаар ингээд ярьж байна бид. Тэгээд ард иргэд дээр, жирийн иргэд дээр энэ аж ахуйн нэгжүүд дээр бол ажил, амьдрал маш хүнд байна. Монгол Улс өрнөөс өрний хооронд хүүгийн дарамтад амьдарч байна. Энэ статистик тоонууд ч гэсэн харуулж байна л даа 24 онд гэхэд өмнөх оныхоо амьдралын чанар, амьжиргааны түвшин, худалдан авах чадвар үндсэндээ ингээд 40 хэдэн хувьтай, 50 хэдэн хувиар ингээд нэмэгдчихсэн. Энэ жил ч гэсэн ингээд бидний хувьд ингээд харж байхад бас л бүгдээрээ 2 оронтой инфляц орлоо, бодлогын хүүгээ ингээд 2 хувиар нэмлээ гээд л. Монголбанк үндсэндээ ажлаа маш муу хийж байгаа маш муу. Жишээ нь 24 онд өмнөх үе оныхоо мөн үеэс хадгаламж 26 хувиар нэмэгдсэн. Юу хариулаад байна вэ гэхээр л үндсэндээ банкны салбар энэ салбарт ажиллаж байгаа энэ салбарынхаа ашиг олж байгаа хэдэн банкнуудаа л хамгаалаад байдаг. Үүний ард Монголын ард түмний амьдрал ямар байгаа вэ гэдэг юмыг ерөөсөө ярихгүй, энэний төлөө ерөөсөө ажиллахгүй байгаа юм шиг ингээд харагдаж байгаа юм. Тэгээд үндсэндээ Монголбанкны өөрийнх нь гол хэрэгжүүлэх ёстой үйл ажиллагаа нь юу гэхээр энэ инфляцыг барих ёстой, мөнгөний нийлүүлэлтийг бодлогоор барих ёстой, бодлогын хүүгээ барих ёстой, төгрөгийн худалдан авах чадварыг хадгалах ёстой байгаад байдаг.

Гэтэл худалдан авах чадвар чинь хэдэн хувиар уначхав? Хариулж байгаа хариулт нь юу ярьж байна гэхээр эх үүсвэр нэмэгдвэл хүү буурна гэж хэлээд байгаа юм. Үгүй эх үүсвэр чинь тэгээд нэмэгдчихсэн байна шүү дээ. Хадгаламж чинь 24 онд өмнөх үеэсээ 26 хувиар өсчихсөн байна шүү дээ. Тэгээд яагаад хүү буухгүй байгаа юм, хэний төлөө ажиллаад байгаа юм? Энийг асуумаар байна л даа. Энэ дээр тодорхой хариулт хэл. Тэгэхгүй бол энэ үнийн өсөлт, энэ хүүгийн өсөлтийг чинь ард түмэн төлж байна шүү дээ, аж ахуйн нэгжүүд төлж байна шүү дээ. Бид нар юуны чинь үндэсний үйлдвэр, юуны чинь ард түмний амьдралыг сайжруулах асуудал энэ юмаа та нар хаячихсан байна шүү дээ. Тэгэхээр энэ юм бол яахын аргагүй энэ хүүтэй холбоотой, энэ зээлтэй холбоотой. Бид нар үнэхээр энэ хүүг бууруулж байж энэ аж ахуйн нэгжийн энэ үндэсний үйлдвэрлэлийн асуудал ярина, ард түмний амьжиргааны асуудал ярина. Ямар ч сайхан хууль гараад ард иргэд дээр очиход бол амьдрал ахуй үнэхээр хүнд байна. Энэ дээр тодорхой бид нар юмыг ярих ёстой энэ Монголбанктай, хариуцлагын асуудлыг ярих ёстой Монголбанктай. Энэ талаар асуух гэсэн юм.

Дараагийн асуудал энэ манай Батшугар гишүүний оруулж ирж байгаа энэ төслийг бол 100 хувь дэмжиж байгаа. Тэгээд энийгээ бүүр сайжруулаад энэ эх үүсвэр тал дээр байгаа энэ 70, 80 хувьдаа зээлийн хүүг бууруулах энэ бодлого дээр ямар гарц, гаргалгаа байгааг ярих хэрэгтэй байна. Энэ хуулийн төсөл дээр бас та бүхэн минь илүү санал оруулж ирээч гэсэн ийм саналыг хэлэх гэсэн юм. Ингээд нэг дэх асуултынхаа хариултыг авъя.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя Энхбаярын Батшугар гишүүн хариулъя.

Э.Батшугар: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгээд нийт хүүгийн, банкны хүүгийн бүтцийг харахад бол та сая хэлж байна эх үүсвэрийн

зардал нь 63 хувь, эрсдэлийн зардал нь 15 хувь, үйл ажиллагааны зардал нь 22 хувь гэж явж байгаа юм. Тэгэхээр бид нар яг энэ хуулиар хаана хэмнэлт хийх вэ гэвэл эрсдэлийн зардал дээрээ 15 хувь дээр тодорхой хэмжээний өөрчлөлт оруулж хэмнэлт хийнэ. Мөн урсгал зардал дээрээ 22 хувь. Энэ ямар каналаар үйлчлэх вэ гэвэл нэгдүгээрт бол иргэн болгоноо таньдаг болчихно банкнууд. Тэгэхээр нэг ёсны том малгайн доор өндөр хүү тавихгүйгээр оноо өндөртэй, санхүүгийн сахилга баттай иргэдээ илүү сайжруулсан нөхцөлөөр зээл олгоно.

Тэгээд тэр зээлээ эргэн төлөлтөө цаг хугацаандаа хийгээд байгаа өөрөө оноо нь нэмэгдээд, эрсдэл нь буураад, тэгээд урамшуулаад явчихна гэж ойлгож болох юм. Үйл ажиллагааны зардал ч гэсэн буурна. Одоо бид нар чинь яг бодит амьдрал дээр юу вэ гэхээр банкны таньдаг эдийн засагч байна уу гээд л яваад л байдаг шүү дээ яг бодит амьдрал дээр. Тэгэхээр энэ зүйл байхгүй болно гэж ойлгож болох юм. Яагаад гэвэл тухайн оноо нь өөрөө тухайн иргэнийг шууд бүх зүйлийг нь илэрхийлчхэж байгаа болохоор заавал өр, орлого болон бусад амьжиргааны орлогынх нь зүйлийг нь судлахгүйгээр өдөрт нь зээл нь олгох бололцоо нээгдэж байгаа юм.

Латин Америкийн судалгаа байгаа юм. Зээлийн шийдвэрийн хугацаа нь 14 хоног, ажлын 10 хоног байсан бол энэ скоринг болон онооны системдээ шилжсэнээрээ 0.6 өдөр болон ажлын 1 өдөр шийддэг болсон. Тэгэхээр зээлийн эдийн засагч нарынх нь цалин, хөлс гэдэг нь өөрөө буураад явчхаж байгаа болохоор бас тодорхой хэмжээнд зээлийн хүү буурна.

Эх үүсвэрийн зардал үнэхээр макро эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой. Энэ нь бол төлбөрийн тэнцэл, инфляц, улсын төсвийн тэлэлт, импорт, гадаад валютын цэвэр урсгал гээд л маш олон зүйлээс хамаарч байгаа л даа. Үндсэндээ бол бодлогын хүү шууд инфляцтай уялддаг. Тэгэхээр бодлогын хүүгээ тодорхой хэмжээнд өндөр байлгаж байж инфляцаа буулгах гээд байдаг, нөгөө талдаа бол, зоосны нөгөө талд нь бол хадгаламжийн хүү, нэг ёсны эх үүсвэрийн хүү нь тодорхой хэмжээгээр бодлогын хүүгээсээ илүү өндөр байж байж хадгаламжаа банкнууд эх үүсвэр татах гээд байгаа юм. Энэ бол шууд утгаараа бас 63 хувийн зээлийн хүү дээр нэмэлт орчхож байгаа юм. Тэгэхээр хамгийн зөв шийдэл юу вэ, яах вэ л гэж бид нар бол яриад байна. Тэгвэл Нэгдүгээрт бол төлбөрийн тэнцлээ сайжруулах ёстой. Төлбөрийн тэнцлээ сайжруулахын тулд тодорхой хэмжээний импортын бараа, бүтээгдэхүүний хязгаарлалт хийх үү, дээрээс нь яаж валютын урсгалаа нэмэгдүүлэх вэ, Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтыг яаж нэмэгдүүлэх вэ, мөн бусад хил боомтын холболт болон бусад уурхайн бүтээгдэхүүнээ, төмөр замын холболтоо яаж эрчимтэй хэрэгжүүлж явуулах вэ л гэдэг зүйл яригдана л даа.

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван хариулт өгье.

Г.Энхтайван: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Яг өнөөдрийн байдлаар зээлийн жигнэсэн дундаж хүү тухайн тайлант сард олгогдсон л 17 хувьтай, үлдэгдлийн хувьд 16.1 хувьтай байна. Зээлийн хүү маань өөрөө нийгэм, эдийн засгийн үндсэн нөхцөл байдлыг илэрхийлдэг. Жишээлбэл, 2021 онд бодлогын хүү 6 хувьтай байхад зээлийн дундаж хүү 13 хувьтай байсан буюу одоогийнхоос ойролцоогоор бараг 4 хувиар бага байсан. Тэгэхээр зээлийн хүүгийн

урьдач нөхцөл нь тухайн Монголбанкнаас барьж байгаа бодлогын хүү байдаг. Бодлогын хүү маань өөрөө инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах үндсэн чиг үүрэгтэй байдаг. Хэрвээ бид бүхэн зээлийн хүүг механикаар хэт бага түвшинд барих юм бол нөгөө талдаа зээлийн хүү гэдэг маань төгрөгийн худалдан авах чадвар байдаг. Төгрөгийн худалдан авах чадварыг механикаар хэт бага түвшинд барих юм бол нийт бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, манай улсын эдийн засгаас гарч байгаа мөнгөн урсгалын гадагшлах урсгалыг бид бүхэн тогтоож чадахгүй. Энэ бол.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. 2 санал хураалт байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг намын бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс тус бүр 2 хүртэл гишүүн асуулт асууж, үг хэлэх, дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх боломжтой.

Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53 гишүүн буюу 54.6 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалтад хариуцлагагүй оролцсон гишүүдийг протоколд тэмдэглэж авахгүй ээ. Иргэдийн зээлийн хүндрэлтэй асуудлыг ярьж байхад анхаарал, болгоомжгүй хандсан гишүүдийн нэрийг дурдах уу? Дараагийн санал хураалт.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “зургаа хүртэлх” гэснийг “таван” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

57 гишүүн буюу 58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

Үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулъя.

14 цагаас чуулганы үдээс хойших хуралдаан үргэлжилнэ.

11.37 цаг

Баасан гараг 09 Тавдугаар сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 00 минут

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

Д.Амарбаясгалан: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлье.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүн Жигжидийн Батжаргал гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан хуулийн үйлчлэх хугацааг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс гэж өөрчлөх саналыг хуулийн төсөлд нэмж тусган хуулийн төслийг эцсийн хувилбарыг болон Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгыг хамт та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хороодын хамтарсан хуралдааны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна.

Нанзадын Наранбаатар гишүүн? Алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Яг одоогоос 1-хэн жилийн өмнө энэ хуулийг баталж байсан. Одоо тэгээд буцааж байна. Тэгээд энэ өөрөө шалтгаан нь юу вэ гэхээр хууль тогтоомж аливаа хууль Улсын Их Хурлаар орохдоо нийгмийн сэтгэл зүй давтагддаг, үгүй бол сошиал медиад хэт өртдөг, тэдний сэтгэл зүйг дагадаг ийм нөхцөл байдал л, нөгөө талаасаа энэ хуулийн төслийн судалгаа маш дутуу байгааг л харуулж байгаа юм л даа.

Тэгээд ганцхан жилийн хугацаанд нийтдээ 66 орчим тэрбум төгрөгөөр 60 орчим сая кг гурил ингээд ороод ирчихсэн. Тэгээд энийг үүний үр дагавар нь юу вэ гэхээр улаан буудай тарих тариаланчид нь байхгүй болсон, хөдөө аж ахуйн салбарынх нь уналтад 28.4 хувиар унасан. Ниргэсэн хойно нь хашхирав гэгчээр бид нар ингээд засах тухай юм болж байна. Энэ сонгуулийн өмнө хүч түрэн баталсан ийм хууль. Тэгээд энэ Энхбаяр сайд тухайн үед байгаагүй байх. Тухайн үед байсан сайд, Болорчулуун энэ газрын дарга энэ тэр яг тухайн үед ямар бодол байр суурьтай байсан юм? Ингээд 1 жил болиод ирэх жил нь өөрчлөөд байдаг ийм хууль тогтоомж ийм тогтворгүй байдал чинь өөрөө бизнес эрхэлж байгаа, газар тариалан эрхэлж байгаа, тэр салбарт ажиллаж байгаа хэдэн 10 мянган хүмүүсийн нөхцөл байдлыг тодорхойгүй болгоод байна л даа.

Ер нь төр өөрөө маш тодорхой байх ёстой юм. Хууль тогтоомж өөрөө байн байн өөрчлөгдөөд савлаад байдаггүй байх ёстой юм. Ингээд үндсэндээ 66 мянган тонн буюу 66 сая кг гурил орж ирснээс болоод 94 мянган тонн улаан буудайн тариалалт байхгүй болоод, борлуулалт байхгүй болчихсон. Тэгээд энэ өөрөө энэ

газар тариалангийн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн хохирол л доо. Үүн дээр Монголын төр Засгийн газар уучлалт гуйсан, эсвэл буруугаа хүлээн зөвшөөрсөн нь ил тод хэлэх хэрэгтэй энэ Хууль зүйн сайд нь. Үйлдвэрлэгч, тариаланч нарын энэ хэмжээгээр борлуулалт буурснаас улбаалаад энэ хэмжээний татварын орлогууд бас байхгүй болсон. Тэгээд бас энэ хуулийн төсөл анх ярьж байхад юу гэж ярьж байсан бэ гэхээр гурилын үнэ хямдарна, гурилан бүтээгдэхүүний үнэ хямдарна гэж маш тодорхой хэлж байсан.

Тэгтэл гурилын үнэ яг бодитойгоор тухайн үед төсөөлж байснаар бас унаагүй, хямдраагүй. Гурилан бүтээгдэхүүний үнэ бүүр хямдраагүй. Тухайн үед энэ Их Хурлын дарга Амарбаясгалан Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа хэвлэлд өгсөн ярилцлага дээрээ гурилан бүтээгдэхүүний үнэ маш үнэтэй байгаа учраас үнэ энэ бас дагаж хямдарна гэсэн байна лээ. Тэгээд одоо болтол энэ гурилан бүтээгдэхүүний үнэ бүр унаагүй 8.4 хувиар дунджаар өссөн байна.

Тэгээд бид нарын ингээд Их Хурлаас гаргаж байгаа шийдвэр өөрөө ийм тогтвортой бөгөөд тодорхой байхгүй бол ингээд жил болгоны дараа ингээд араас нь өөрчлөлт оруулах болдог, эсвэл ингээд буцаах болдог ийм байдлыг бид нар дахиж ингээд цаашдаа гаргамааргүй байгаа юм.

Одоо ингээд 2025 оны газар тариалангийн улирал аль хэдийнээ эхэлчихсэн байхад тариаланчид юу тарих нь тодорхойгүй байна шүү дээ. Саяхан хүртэл ингээд зарим компаниуд бид нар энэ жил улаан буудай тарихгүй, яагаад гэвэл тодорхойгүй байгаа асуудал ингээд ярьж байгаа байхгүй юу. Одоо энэ юу болох вэ гэхээр гурил ба гурилан бүтээгдэхүүний чинь үнэ өснө гэсэн үг. Энэ хариуцлагыг хэн хүлээх юм? Өнгөрсөн 1 жилийн алдагдлын хариуцлагыг нь хэн хүлээх юм? Гаргасан шийдвэртээ энэ төрийн захиргааны төв байгууллагууд буруугаа хүлээн зөвшөөрч уучлалт гуйх юм уу? Энэ дунд нь ингээд тодорхойгүй байн байн өөрчлөгдөж байгаа нөхцөл байдлаас чинь болоод энэ салбарт ажиллаж байгаа, бизнес эрхэлж байгаа албан хаагчид тэр компанийн ажилчид ингээд тухайн үед ингээд бүтэн хохироод байгаа байхгүй юу. Энэ Болорчулуун дарга миний мэдэхийн Хөдөө аж ахуйн яаманд маш олон жил ажилласан. Та харамсахгүй байна уу ийм салбар ингээд унагаачхаад, буцаж ийм явж байгааг? Таны сэтгэл зүрх чинь өвдөхгүй байна уу? Та тухайн үед яагаад энийг ингээд хэлээгүй юм болохгүй гэдгийг нь? Тэгээд ийм л үг л хэлэх гэсэн юм. Ер нь ингээд төр засгаас гарч байгаа, Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэр, судалгаануудаа маш сайн хийдэг байхгүй бол ингээд судалгаа дутуу, тооцоолол дутуу ингээд араас нь л ийм нөхцөл байдалд засаж залруулдаг, нэргэсэн хойно хашхирдаг л болчихоод байна л даа. Энийг хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Шижир гишүүн аль өнцгөөс харах нь чухал юм шиг байгаа юм. Хэрэглэгчдийнхээ эрхийг худалдан авах чадвар нь муудаад байгаа, орлого багатай иргэдийнхээ амьжиргааг дэмжих чиглэл дээр бодлого гаргаж байгаа юу, эс үгүй бол тодорхой салбар дээр байгаа зарим төрлийн нөлөөлөл үзүүлээд байдаг нөхдүүдийн өмнөөс асуудалд хандаж байгаа юу гэдэг дээр их өөр байх. Шинэ шийдвэр гарсантай холбоотойгоор гурилын үнэ нэгдүгээрт өсөөгүй, дээд гурил, 1 дүгээр гурилын үнэ 10 орчим хувиар буурсан, 1 дүгээр гурилын үнэ 14 орчим хувиар буурсан гэдэг үзүүлэлтүүд байж байгаа юм.

Мэдээж хар аа бизнесийнхээ эрх ашгийг хамгаалах, орчныг тогтвортой байлгах гэдэг зүйл бол ялт ч үгүй төрийн бодлогын эн тэргүүнд байх ёстой зүйл. Нөгөө талдаа салбарын бодлогоос нь хамаараад хэрэглэгчид хүндрэл үүсэж байгаа нөхцөлийг хэрхэн, яаж зохицуулах вэ гэдэг нь бас л төрийн асуудал. Иргэдийнхээ эрхийг хамгаалах дээр ажиллаж л байх ёстой. Тэгэхээр энийг бас мэдээллүүдээ зөв хараад, зөв аваад, тоогоо бас зөв хэлэхгүй бол бас буруу, зөрүү ойлголт мэдээллүүд нийгэмд явдаг.

Энхбаяр сайд хариулт өгөх үү та? Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Засгийн газраас өнгөрсөн онд өргөн барьсан хуулийн төсөл нь 23, 24 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй холбоотойгоор тэжээлийн дутагдал, гурилын үнийн тогтвортой байдлыг хангах үүднээс 25 мянган тонн гурилыг баруун бүс нутгийн тодорхой боомтоор импортлон оруулах асуудлыг л өргөн барьсан юм. Тэр 25 мянган тонн гэж өргөн барьсан тэр тоо хэмжээ Их Хурлын хэлэлцүүлэг дээр орж ирээд бүх боомтоор хязгааргүй, татваргүй болж хувирсан. Тэгэхээрээ яам өөрөө бодлого нь дутагдлыг тодорхой бодлого явуулаад зохицуулъя, тэр эрхээ засаг авъя гэдэг л санаа шүү дээ. Тэрийг нь өнгөрсөн парламент үгүй энийг 100 хувь бүх боомтоор татваргүй, квотгүй, хязгааргүй нэвтрүүлнэ гэдэг л өөрчлөлт хийчихсэн буюу анх өргөн барьсан үзэл баримтлалаас нь өөрөөр батлагдсан гэсэн үг.

Тэгэхээр мэргэжлийн, салбарын яам бол салбараа хамгаалсан бодлого оруулж ирсэн шүү. Тэгэхээр тэн дээр гишүүд өөр өөрөөр ойлгоод байна. Тэрийг их онцгой бас бодоорой. Яам бол хамгаалах буюу яг тодорхой зохицуулалтаа хийх бодлогоо оруулж ирсэн. Одоо энэ хууль хэрвээ дэмжигдвэл бид яг энэ зохицуулах эрхээ л олоод авах юм. Тухай тухайн жилийн ургацын байдалтай уялдуулаад л, нөөцөө зөв бүрдүүлээд л аль боомтоор суллах вэ, аль боомтоор хязгаарлалт хийх вэ, аль төрөл дээр нь квот олгох вэ гэдгээ Засаг өмнө нь зохицуулаад ийм хурдан шуурхай байдлаа хангаад явж байсан юм. Хууль гаргаад ингээд түгжчихээр энэ хуулийн процедур буюу үндсэндээ бүтэн жил болчихож байгаа юм. Намрын чуулганд өргөн барьснаас хойш өнөөдөр хэлэлцэж байна гэдэг маань бас л жоохон хариуцлагагүй байдал үүсчхээд байгаа юм л даа. Тариалалт жигдэрч байдаг. Бид бодлого гаргаж чадаагүй байдаг. Тариаланчид эргэлзээтэй байдалд орсон. Үр дүнд тариалалт нэлээн, улаан буудайн тариалалт нэлээн унахаар ийм бодитой байна. Намрын ургац улаан буудайн ургац багасах нь тодорхой байна. Тэгэхээр гурилын тодорхой дутагдал үүсэх нь тодорхой болж хувирч байна. Үнэхээр бид цаг хугацаа алдчихлаа.

Тэгэхээр газар тариалан гэдэг цаг хугацаатай уралдаж явдаг болохоор нөхөөд тарина гэдэг бололцоо байдаггүй. Тэгээд өөр таримал руу их хүчтэй шилжиж байгаа байдал. Тэгэхээр бид 26 оны төсөв дээр тодорхой хэмжээний 100-аас доошгүй мянган тонн улаан буудайн нөөцийг бүрдүүлэх асуудлыг оруулахаас аргагүй болж байгаа гэсэн үг. Тэрийг тэгээд төсвийн үед бүгдээрээ ахиад задлаад ярих байх гэж.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Бид нар 1 жилийн настай хуулийнхаа тухай, хуулийн тухай ингээд хуулийн өөрчлөлтийн тухай яриад л сууж байна л даа. Ер нь үүгээр сүүлийн

шинэ эдийн засгийн харилцаанд орсноос хойших энэ 30 гаран жилийн энэ хөдөө аж ахуйн салбарын бодит байдлаа бид нар ер нь энэ Монгол Улс ийм дүгнэж цэгнэж ярих гарцаагүй ийм шаардлага л үүсчхээд байна. Ер нь бид нар хаанаасаа хаашаа явж байгаа юм бэ? Ямар үр дүнд хүрсэн, одоо яг яах гээд байгаа юм? Яг цөөн тоо яривал эдийн засаг дахь оролцоо хөдөө аж ахуйн салбар, мал аж ахуйн газар тариаланд бүгдээрээ нийлээд эдийн засаг дахь оролцоо 10 гаруйхан хувьтай болчихсон. Тэр салбарт ажиллаж байгаа хүмүүсийн цалин, орлого улсын дунджаасаа хэд дахин доошоо болчихсон. Бүтээмж, технологи гэдэг зүйлийг тэр салбарт нэвтэрдэггүй, тэр салбарт хөшүүрэгддэггүй ийм л салбар бий болоод юм. Үндсэндээ бараг ингээд хоцрогдлын туйл болчихлоо. Төр засгаас гоё гоё юм ярьдаг бид нар дэмжиж байна гэдэг төсөл, хөтөлбөр олон олон зүйлүүдийг гаргадаг. Яг энэ бодлого нь дэмжээд ч байгаа юм шиг, дэгээдээд ч байгаа юм шиг ийм бодлого, тэр малчдыг дэмжинэ гэнэ явсаар явсаар байгаад мах нь үнэтэй байхыг бид нар дэмждэггүй. Мах өсчихөөр мах өсчихлөө, махны үнийг нь буулгах ёстой гэдэг бодлого ярьдаг.

Тэгвэл тэр дэмжлэгүүд чинь дэмжлэг юм уу, дэгээдэлт юм уу? Ноос, ноолуур нь жаахан өсөх болохоор явсаар байгаад тэр нь элдэв янзын боловсруулалт, хил, гааль, татвар гээд бас эргээд нөгөөдхийгөө дэгээдчихдэг. Уг нь бол тэр гарч байгаа бараа, бүтээгдэхүүн нь яаж үнэтэй байх юм гэдэг энэ зүйл рүүгээ л хэдүүлээ явахгүй бол дэмжиж байгаа нэртэй бараа, эцсийн бүтээгдэхүүн нь бүгд үнэ цэнгүй, арьс шир, ноос, ноолуур, мах шөл, бүгдээрээ л үнэгүй. Тэгсэн мөртөө асар их дэмжиж байна гэдэг, дэмжлэг авч байгаа нэртэй хэдэн хөдөөгийнхөнд яг үнэндээ.

Тэгэхээр одоо цаашид гол нь яах юм бэ? Ингээд ийм нүүдлийн мал аж ахуйн гоё сайхан ингэж хошхируулаад ийм үзүүлэн шиг ингээд л улс төрчид нь хошхируулаад яваад байх юм. Яг ямар үнэлэлт, дүгнэлт өгч бодлогын ямар өөрчлөлт, энд бүр жижиг биш асар том хэмжээний бодлогын өөрчлөлтийг л бид нар ярихгүй бол бие биеэ хуурахгүй бол энэ дээр ярихгүй бол үнэхээр хэцүү болчихлоо шүү дээ. Евроази гээд гоё сайхан юм ярьж байна.

Гэтэл гадагшаа тэр мах шөл чинь гарахаасаа урьдаар хорио цээр, халдварт өвчний асуудал нь юуг нь ч шийдээгүй, ямар ч алхам хийгдээгүй. Тэгээд л тэнд гоё сайхан зүйл л ингээд яригддаг. Малаа халдварт өвчнөөс чөлөөлөх гэдэг юм уу, эрүүлжүүлэх олон улсын стандарт руу алхам алхмаар жаахан ойртох энд ямар нэгэн бодлогын өөрчлөлт ингээд байхгүй. Тэгээд л ийм жилийн настай хуулийг нааш цааш гэж яриад л ийм л юм л болчихлоо.

Тэгээд энэ дээр яам өөрөө ямар бодлого бодож байдаг юм? Ингээд сар сараар, жил жилээр бид нар ингээд яваад байх юм уу? Одоо нөхцөл байдлыг бие биедээ үнэнээрээ хэлээд, бодит байдлаа илүү тийм бодлогын том өөрчлөлтийг энэ бодлогын өөрчлөлт ер нь жижиг биш нэлээн тийм том хэмжээний өөрчлөлтийг л нөхцөл байдал бид нараас шаардаж байна. Тэр салбар тэр хүн ард чинь үнэндээ тэр орлого ашиг, бүр олон улсыг нь дүүрч зүгээр улсын дундажтайгаа ч харьцуулахын аргагүй. Тэнд залуучууд, шинэ боловсон хүчин, техник технологи, бүтээмж гэдэг зүйлийг бүр ярилтгүй ийм салбар боллоо шүү дээ. Тэгээд энэ дээр яам ямар бодлого, чиглэл барьж байдаг юм? Ингээд бид нар зүгээр л аргацаагаад, бие биеэ хуураад л ингээд яваад байх юм уу? Жилийн наана цаана хойш, урагшаа

болоод. Энэ дээр бодлогын өөрчлөлт төлөвлөж байгаа зүйлүүд байдаг бол хэлж өгөөч.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Үндсэндээ сүүлийн 30-аад жил бид хэт уул уурхайд түшиглэсэн ийм өрөөсгөл эдийн засгийн бодлого эдийн засгийн бүтцийг л бий болгосон. Тэрнийхээ бас эрсдэлийг ч амсаж байгаа. Уул уурхайгаас ангид эдийн засгийн тулгуур гол салбар бол хүнс, хөдөө аж ахуйн салбар, хөнгөн үйлдвэрлэлийн салбар үйлдвэрлэдэг байж байж улс орон тогтвортой хөгжинө. Бид хэрэглэгч болчихсон. Энэ КОВИД-оор маш тодорхой илэрсэн шүү дээ. 1 сарын хүнсний нөөц байхгүй, дандаа импорт, хил гааль хаагдсан хүнсний нөөцгүй. Эндээс л хөдөө аж ахуйгаа сэргээх, босгох, үндэсний дотоодын үйлдвэрлэлийг бий болгох, бэхжүүлэх ийм зорилт гарч ирсэн. Энэ маань Цагаан алт хөтөлбөр, Атрын 4 дүгээр аян, Хүнсний хувьсгалаар нэр томьёолоод хэрэгжээд Их Хурал бодлого гаргаад явж байгаа маань энэ. Эцсийн гол зорилго бол үйлдвэрлэгч, мөн экспортлогч салбар болох. Ахиц дэвшил их бий. Дотооддоо бид нар энэ Хүнсний хувьсгалын үр дүнд нэлээн олон үйлдвэртэй болоод авлаа. Нэлээн олон 100 шинэ бүтээгдэхүүнтэй сав баглаа, боодлоо сайжруулаад авлаа. Та мах ярьж байна махны экспорт бид 30 жил мөрөөдсөн шүү дээ. Мах гаргая гэж. 2 жил дараалаад 300 сая долларын мах бид экспортод гаргаж чадлаа. Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах юм бол ерөөсөө л экспорт. Газар тариалангийн бүтээгдэхүүн ч экспорт, мал аж ахуйн бүтээгдэхүүн ч экспорт. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэмүү өртөг үйлдвэрлэх тал руу л явж байна. Энэ бүх бодлого чинь цогц. Энэ хэдэн бодлого чинь хоорондоо ингэж уялдаж яваад байгаа.

Тэгэхээр энэтэй холбоотойгоор жишээлбэл мал, мах яагаад ингэж олон зуун сая доллароор экспорт хийгээд эхлэв гэж. Энэний цаана чинь олон улсын гэрээ хэлэлцээр, мал эмнэлэг, малын вакцинжуулалт, эм бэлдмэл, тэр ажил ахицтай байгаагийн үр дүнд л экспорт гараад байгаа шүү дээ. Манай мал эмнэлгийн үйл ажиллагааг л олон улсад хүлээн зөвшөөрч байгаа болохоор манай мал, махыг аваад эхэлж байгаа юм шүү дээ.

Энэ жилийн тухайд ноолуурын асуудал их хөндөгдөж байна. Бид Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд ноолуурынхаа үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмж чадсан тулдаа, самнах хүчин чадлаа хийж чадсан тулдаа ноолуурын үнийг унагаахгүйгээр малчдаас авч чадаж байна шүү дээ. Хэрвээ бид нар энэ бодлогыг хэрэгжүүлж чадаагүй бол өнөөдөр ноолуурын үнэ 50-70 мянган төгрөг дээр унахаар байна шүү дээ. Харин үндэсний үйлдвэрлэлтэй байсан тулдаа бид 120-165 мянган төгрөгт үндсэндээ зүүн бүс аваад дууслаа, төвийн бүс аваад дуусаж байна. Одоо говийн болон баруун бүс эхэлж байна. Тэгэхээр хөдөө аж ахуйгаа ерөөсөө экспортын чиг үүрэг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Тийм яг ноолуурын үнэ 100 гаруй гэдэг хэдэн жилийн миний санаж байгаагаар 10 гаруй жилийн өмнө л ийм л үнэтэй байсан. Одоо тэгээд долларын ханшид шилжүүлээд 1 долларт шилжүүлбэл энэ маань ямар үнэтэй байгаа юм. Ер нь хөдөө аж ахуйн салбарыг дахиад л үзэхэд л 60 гаруй сая малтай, хурга, ишиг, тугал, унаганаас нь аваад бүгдийг нь тоолоод дундаж үнэ гаргаад

үржүүлбэл энэ тоо юун том байтугай бараг дунд хэмжээний ч уурхайд хүрэхээргүй ийм баялаг. 60 сая малыг үржүүлбэл бүүр 10 их наяддаа хүрэх үү, үгүй юу? Тэгээд энэ чинь зүгээр орлогын тухай яриа биш нийт балансын дүн, хөрөнгийн тухай л яриа.

Тэгэхээр үнэхээр энэ салбар өөрөө эдийн засаг дахь оролцоо энийг дагасан тэр 200-гаад мянган малчин айл өрх энэ бүх хүмүүсийн энийг дамжиж байгаа тэр ашиг, орлогын тухай яриа энэ тэр бол үнэхээр ийм цааш цаашдаа энэ бол ийм эдийн засаг биш утга учиргүй тийм амин зуулгын тухай яриа болж хувирч байгаа

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд нэмэлт хариулт өгье.

Ж.Энхбаяр: 60 сая мал, 1 сая газар тариалангийн газар байгаа юм. Энэ дээр тулгуурлаж л хөнгөн хүнсний үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байгаа. 600 мянган хүн энэ салбарт ажиллаж, амьдарч, амин зуулгаа хангаж, энэ эдийн засгаасаа илүү улс төр нийгмийн маш том ач холбогдолтой салбар. 600 мянган хүн ахуйгаа, аж ахуйгаа эрхлээд орон нутагтаа эзэн болоод амьдарч байгаа. Тэр нүүдлийн мал тэр нүүдлийн уламжлал соёлыг үүгээр дамжуулж хадгалалт хийж байгаа.

Тэгэхээрээ хэт уул уурхайд түшсэн бодлогоосоо бид хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг дэмжсэн төсвийн бөгөөд бодлогын ийм арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхгүй бол болохгүй гэдэг таны саналтай нэг байна. Боломж байна. Бид нөөц чадавхынхаа 20 орчим хувийг л ашиглаж байна. Ер нь экспортын бөгөөд үйлдвэрлэлийн бололцоо их байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Энэ улаан буудайн ч юм уу, энэ гаалийн татвараас чөлөөлөх тухай гээд энэ асуудал дээр 2 санал хэлье. Хөдөө аж ахуйн сайдын хэлээд байгаа тийм тийм. Ер нь бол энэ нүүдлийн мал аж ахуй, газар тариалан үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж байж л бид нар цаашаагаа эдийн засгийн хувьд бэхжиж, тодорч суурьших юм байгаа юм.

Тэгэхлээр энэ улаан буудай эрхлэгчид, үйлдвэрлэгчдийн хувьд бол ингээд гантай жил ургацаа алдчихдаг, өнтэй жил бүгдээрээ ургац авчихлаар зарж чадахаа байчихдаг, хадгалж чадахаа байчихдаг, тэгээд сүүлдээ бүүр үнэгүйдүүлэх юм уу, эс үгүй бол хадгалалтын горим алдсанаас чанараа алдчихдаг. Тэгээд энэ гол нугарлын цэг нь бол ерөөсөө л энэ ложистикийн систем буюу энэ чанарыг нь муутгадаггүй хадгалдаг, улаан буудай үйлдвэрлэсэн хүн болгон тодорхой тогтмол үнээр авчраад тэр агуулахдаа өгчихдөг, тэндээ баталгаатай байр суурьтай хадгалж байдаг. Эндээсээ улс орны гурил, буудай эрхлэгчид нь тогтвортой байдлаар дараагийнхаа түүхий эдээ авч байж энэ ложистикийн тогтолцоо бүрддэг гэж ингэж үздэг юм байна лээ.

Гэтэл манайд өнөөдөр бол яг ийм тогтолцоо бүрдсэн үү? Дахиад улаан буудай үйлдвэрлэгчид тэр 1 сая га газар дээрээ ч тариалаад ирсэн. Тариалсан буудайгаа санаа зовохгүйгээр зарах тэр ложистикийн тогтолцоонууд нь бэлэн болсон уу гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаарт, ерөөсөө энэ гурил үйлдвэрлэгчдийн асуудал дээр чинь дотоодын зах зээлээ дэмжих ёстой, дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжих ёстой гэж ярьж байгаа. Энэ ялт ч үгүй зөв л дөө. Гэхдээ монопол шинж чанартай, олигопол шинж чанартай, үнээ хиймлээр өсгөдөг энэ шинж чанар дээр дотоод зохион байгуулалтыг яаж шийдэж байгаа вэ? Цаашдаа энэ цөөхөн хэдэн үйлдвэрийн гурилууд чинь бусдыгаа шахаад, үнээ хиймлээр өсгөөд, дээрээс нь гадна талаас ингэж татвараас чөлөөлүүлээд, дотоодын гурилын үнэ өсөхгүй гэх баталгаа байна уу?

Гуравдугаарт баруун бүс нутаг ер нь бол энэ тээвэр ложистикийн хувьд алслагдсан. Баруун бүс нутгийн тэр 25 мянган тонн гурилыг л татвараас чөлөөлье гэж оруулж ирээд ингээд бүгдийг нь чөлөөлчихсөн юм байна. Тэгвэл одоо энийгээ болиод баруун бүс нутгийнхан нь ингээд чөлөөлөөд татваргүй болгодог чигээр нь ингэж оруулж ирэх боломжтой юу? Ер нь энэ нүүдлийн мал аж ахуйн ложистикийн тогтолцоо буюу энийг байнгын худалдан авалтын системийг л оруулж ирж байж газар тариалан, нүүдлийн мал аж ахуйн эдийн засгийн эргэлтэд орно гэж байна. Энэ дээр явуулж байгаа таны бодлого юу байна?

Хоёр дахь нь саяын тэр баруун бүсийг гурилын үнэ өсөөгүй гэсэн дээр баруун бүсийг гурилын үнэ өсөхгүй гэсэн баталгаа байна уу? Гуравдугаарт олигопол, монопол шинж чанартай зах зээл тогтоож үнэ хиймлээр өсөхгүй байх баталгаа байна уу? Дөрөвдүгээрт баруун бүс нутгийг 25 мянган тонн гэдэг ч юм уу тэр хэмжээгээр нь татвараас чөлөөлөх тийм болгож өөрчлөх боломж байна уу гэсэн ийм 4 асуултыг танаас асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуй өөрөө дэлхий нийтээрээ л их эрсдэлтэй салбар. Тухайн жилийн хур тунадасны хэмжээ, гангийн байдал гээд олон зүйлтэй шалтгаалж үнэ байнга л хөдөлж байгаа. Гурилын асуудалтай холбоотойгоор судалгаанууд хийгдсэн. Үнэ хаана өсөөд байна? Үнэ худалдаан дээр их өсөж байна, тээвэр дээр өсөж байна. Гурилын үйлдвэртэйгээ уулзсан.

Өнөөдөр 1 дүгээр гурил 1500 төгрөгөөр үйлдвэрээс гарч байна. 1500 төгрөгөөр Баян-Өлгий аймагт хүргэж болно. Тэр тээврийн зардлыг яах юм бэ гэж. Одоо бол гурилын үйлдвэрүүд хүргэдэггүй, бөөний худалдаачид буюу гурилын ченжүүд үйлдвэрээс аваад үнийг зохицуулалт хийж байна бодлого. Энд төрийн оролцоо байхгүй худалдаан дээр. Худалдаа, тээвэр дээр гол өсөлт хийж байна. Тэрнээс үйлдвэр дээр өсөлт гараагүй. Яам буудайгаа тарьж байна, ургац тогтмолжиж байна, 100 хувь дотроо хангаж чадаж байна, 100 хувь үйлдвэрлээд бүтээгдэхүүн хийж чадаж байна. Яаж иргэдэд хүргэх вэ энэ алслагдсан улс орны бүс нутгийн ялгааг яаж арилгах вэ гэдэг асуудал байгаа юм.

Тэгэхээр тооцоо хийсэн баруун бүс нутгийн 25 хувийг хангахад ямар тээвэр ямар даацтайгаар явахад ямар зардал гарах вэ? 6 тэрбум төгрөгийн тээврийн зардал гарч байна. Хэрвээ 6 тэрбум төгрөгийн тээврийн зардлыг шийдсэн нөхцөлд Улаанбаатарт байгаа 1500 төгрөгийн гурил Баян-Өлгий аймгийн төвд 1500-гаар очиж чадна. Тэгэхээр энэ бодлогыг 26-ны төсөв дээр бид нар суулгаж оруулж ирнэ. Нэг.

Баруун бүсийн бодлого баруун бүс нутагт газар тариаланг хөгжүүлэх ганц том нөөц бол Увс аймгийн Баруунтурууны хуучин сангийн аж ахуй. Тэнд байгаа 50 орчим мянган га талбайг эргэлтэд оруулах, тэнд техник шинэчлэл хийх, бодлогын дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй зээл гэсэн бодлогыг бас 26 оны төсөвт оруулж ирнэ. Тэрүүгээр асуудлыг шийднэ. Одоо ажлын хэсэг Увс аймагт очиж газар дээр нь ажиллахаар бэлтгэл ажлаа хангаж байгаа.

Мөн хангайн бүс нутагт бас нөөц бол Хархорины сангийн аж ахуй буюу Хархорины тэжээлийн сангийн аж ахуй, тэжээлийн баазыг нэмэгдүүлэх бодлогыг бас оруулж ирнэ. Ингэх юм бол Хархорин дээр тулгуурласан хангайн бүсийн эрсдэл Увс аймагт тулгуурласан баруун бүсийн энэ тэжээлийн, үр тарианы энэ нөөцийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх бүрэн бололцоотой.

Гэхдээ зөвхөн яг чиглэсэн, нэрлэсэн ийм бодлогын ийм хөнгөлөлттэй зээлийн бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа.

Энэ жилийн тухайд бэлэн бүтээгдэхүүн буудайн нөөц хангалттай тул 25 оны ургац хураалт болтол үнийн хувьд ямар нэгэн өөрчлөлт орохгүй, тогтвортой байдлыг хангаж чадна гэж гурилын үйлдвэрүүд, гурилын үйлдвэрийн холбоо албан ёсоор мэдэгдсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Түвшин гишүүн тодруулж асууя.

Б.Түвшин: Тэгэхлээр ерөнхийдөө энэ тариаланчдыг дэмжих хамгийн гол чухал цэг нь бол ерөөсөө нэгдсэн худалдан авалтын систем буюу тэд нарын үйлдвэрлээд авсан ургац тариаг чанарыг нь хадгалуулахгүй хадгалдаг ложистикийн системийгээ зохион байгуулдаг. Энэ ложистикийн системээсээ цааш нь хүнсний үйлдвэрүүд гурил руугаа тасралтгүй байдлаар хүргэдэг энэ ложистикийн тогтолцоо дээр бол төр бодлого боловсруулах нь зүйтэй байх гэж ингэж бодож байна.

Хоёрдугаарт, тээврийн зардал гэхээсээ илүү энэ үнэ үндэсний хэмжээний энэ ложистик тээврийн асуудлыг шийдэхгүй бол одоо мал, мах ч гэсэн тэгж байна шүү дээ. Гадаадын Хятадын ченж орж ирээд л махнуудыг өөрсдийн гар, хөлүүдээрээ цуглуулж аваад л экспортлоод гараад явчихдаг. Малчдад нь үлдсэн юм байхгүй, дотоодын зах зээл дээр үлдсэн юм байхгүй. Тэгэхлээр бид нар магадгүй энэ Евроазийн зах зээл рүү орсон ч бай, Хятадын экспорт хийсэн ч бай, Арабын экспорт хийсэн ч бай үндэсний өөрийн ложистик тогтолцоо гэдэг юмтай бол.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Тантай санал нэг байна. Ер нь Худалдааны хуулийг л яаралтай гаргамаар байна. Монгол Улсад худалдаа зохицуулалтгүй байгаа. Дотоод болон гадаад худалдаа зохицуулалтгүй. Хэдээр ч нэмж болно, хэдээр ч зарж болно. Тэнд ямар нэгэн төрийн зохицуулалт, хязгаарлалт байхгүй байгаа юм. Тэгэхээр гол өртөг үнэ худалдааны болон тээвэрлэлтээр үүсэж байгаа. Энд төрийн буюу зохицуулах бид нар ийм арга механизм байхгүй байгаа юм.

Нөгөө талаар тарьсан будаа баталгаатай борлохын тулд бид нөөц бүрдүүлэх ёстой. Ер нь стратегийн бүтээгдэхүүн гэж үзэж багаар бодоход 100 мянган тонны улаан буудайн нөөц улсад байж байх ёстой. Тэгж байж тогтворжуулалтыг хангаж үнийн савлагаанаас хамгаалсан инфляц нөлөөллийг бууруулах бодлого байгаа юм. Тэгэхээр 26 оны төсөвтөө би энэ бүх бодлогыг оруулж ирнэ. Энэ үед гишүүд маань дэмжиж өгөөрэй гэдгийг хүсье.

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Тэгэхээр гаднаас импортын гурил татваргүй оруулахаа зогсооё тэгээд өөрсдөө хүнсээ хангадаг болъё, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлье гэдгийг би дэмжиж байгаа. Гэхдээ гурил, улаан буудайн үнэ өртгийг тогтвортой байлгах талаар энэ төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлогыг илүү хариуцлагатай болгох, тэнцвэртэй, хүртээмжтэй болгох тухай дээр бас 2, 3 зүйлийг тодруулж асууя гэж бодож байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд гурилын үнэ жил тутам 10 гаруй хувиар нэмэгдээд 2014-тэй онтой харьцуулах юм бол 2025 онд гурилын үнэ 4-5 дахин нэмэгдээд байна гэсэн ийм тоо статистик байгаа.

Тэгэхээр энэ гурилын үнийг тогтвортой барихын тулд тийм л дээ өнгөрсөн жил импортын гурилд татвар ноогдуулсан. Энэний үр дүнд яах вэ огцом өсөлтийг сааруулсан. Гэхдээ гурилын үнэ ердөөсөө 100-аас 200 төгрөгөөр л буурсан байгаад байдаг. Энэний учир цаад шалтгаан нь болоод ирэхээр бид нар сайн мэдэж байгаа тариалалтыг нь бууруулсан, үйлдвэрлэлийнхээ хэмжээг бууруулсан, бүүр цаашлах юм бол гурил үйлдвэрлэх гол түүхий эд улаан буудайгаа импортоор ахиухан аваад дотоодын тариалан эрхлэгчдээсээ тун бага хэмжээгээр авсан гэх жишээтэй иймэрхүү юмнууд байгаад байгаа шүү дээ.

Тэгээд ер нь харахад энэ гурил, улаан буудайн зах зээл дээр өрсөлдөөн маш хязгаарлагдчихсан юм байна гэж харагдаж байгаа. Үйлдвэрлэлийн хувьд, нийлүүлэлтийн хувьд, үнийг тогтоохын хувьд бас цаана нь зах зээлийн далд хүч үйлчилдэг болчихсон юм уу гэсэн ийм зүйл анзаарагдаад байдаг. Тэгэхээр би салбарын сайдад хандаж 2, 3 зүйлийг тодруулж асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт нь энэ төрөөс үзүүлж байгаа энэ татаас, хөнгөлөлттэй зээл, энэ гадаадын зээл, тусламжаас энэ газар тариалан болон хүнсний үйлдвэрлэл тэр тусмаа гурил үйлдвэрлэж байгаа энэ үйлдвэрүүдэд үзүүлж байгаа энэ дэмжлэг, туслалцааг илүү хариуцлагатай, үр ашигтай болгох тухай дээр бодлогодоо ямар өөрчлөлтүүдийг хийж байна вэ? Тэр энэ төрөөс дэмжлэг авч байгаа энэ байгууллагуудыг илүү гэрээнийхээ үүргийг биелүүлдэг болох тал дээр нь та бас өөрийнхөө бодлогодоо ямар шинэ арга замуудыг тусгаж байгаа вэ гэж нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт нь газар тариалан эрхлэлтийн энэ салбарт 600-гаад аж ахуйн нэгж ажил үйл ажиллагаа явуулж байгаа гэж байгаа. Тэрний дийлэнх нь мэдээж хэрэг шинэ, жижиг аж ахуйн нэгжүүд байгаа байх. Тэгэхээр тэд нарт энэ төрийн дэмжлэг, татаасыг тэнцвэртэйгээр хүргэдэг байх, тэд нарыг бас энэ өсөж хөгжих энэ боломжийг нь тэд нарт нээж өгөх энэ тухай дээр та өнөөдрийн энэ бас бодлогодоо ямар зарчмын өөрчлөлт хийж байгаа вэ гэж асуумаар байна.

Гуравдугаархад нь одоо ингээд Атрын 4 дүгээр аян гээд эхэлж байна. Тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бүрдүүлнэ гээд ийм 2 том зорилттой Атрын 4 дүгээр аяны үйл ажиллагаа эхэлж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ зорилтод чинь шинжлэх ухаан, эрдэм шинжилгээнд суурилж энэ газар тариалангийн бүтээмжийг нэмэгдүүлэх тухай санаанууд энд орох уу? Өөрөөр хэлэх юм бол хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллах замаар ядаж бордоогоо дотооддоо хийдэг болчихъё, ядаж хортон шавжтайгаа тэмцдэг бодисуудаа дотооддоо хийдэг болчихъё, олон улсын чанар стандартад нийцсэн найдвартай сайн лабораторитой болчихъё. Тэгэхээр энэ шинжлэх ухаан, энэ талын шинжлэх ухаанд хөрөнгө оруулалт хийх ийм зүйл таны энэ зорилтод тэр хөнгөлөлттэй зээлийн хуваарилалтад энэ тухай санаанууд тусах уу? Ингэх юм бол магадгүй улаан буудайн өртөг бас арай жаахан хямд болох бас дэмтэй байх юм болов уу гэж бодоод байгаа юм. Тэгээд энэ 3 зүйлийг танаас тодруулъя.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Сүүлээс нь хариулъя Хэрлэн гишүүн ээ нэг гайхалтай зүйл байгаа хөдөө аж ахуйн салбарыг бодлогоор унагаасан юм шиг л юм харагдаад байгаа өнгөрсөн 30 жилд. Өнөөдөр хөдөө аж ахуйн шинжлэх ухааны гол байгууллагууд бүгд өөр яамны харьяанд байгаа. Мал аж ахуйн хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн энэ ойлгогдохгүй байгаа юм. Салбарын хүний нөөцийг бэлддэг бага, дунд, дээд мэргэжлийг бэлддэг сургууль, ТМС-үүд бас өөр яамны харьяанд байгаа юм. Яам боловсон хүчнийхээ бодлогоо мэдэхгүй, салбарын хөгжүүлэх шинжлэх ухааны бодлогоо мэдэхгүй тусдаа байгаа. Энийг яаралтай засаж, залруулахгүйгээр цаашаа хол явахгүй буюу бүтэц буруу байна гэсэн үг.

Хоёрдугаарт Атрын 4 дүгээр аяны гол зорилго юу юм бэ гэж. Газар тариалан, мал аж ахуйн төгс хослолыг бий болгох, хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэглээ, хөнгөн, хүнсний үйлдвэрүүдээ тогтвортой, чанартай эх орны түүхий эдээр хангах ийм зорилготой. Атрын 1, 2 дугаар аян буюу 50, 60 оны хугацаанд хүн ам 1 сая байхад 1 сая га газрыг бид нар эргэлтэд оруулж ашигласан. Одоо хүн ам 3.5 сая, ойрын хугацаанд 4 сая, мөн дээрээс нь жилдээ сая орчим жуулчин ирж энэ хүнсний хэрэглээнд нэлээн том бодитой нөлөө үзүүлдэг болчихоод байна. Одоо байгаа газар, энэ өгөөж нь энэ хэрэглээгээ хангаж дийлэхгүй болсон. Нөгөө талаас мал аж ахуй эрсдэлээс хамгаалахын тулд малын тэжээл таримлын олон сорт, төрлийг нэмэгдүүлэх, тэжээлийн баазыг сайжруулах, энэ гахай, тахиа, шувуу, өндөг, сүүний аж ахуйнууд, эрчимжсэн аж ахуйнуудыг хангахын тулд өндөр ашигт, уурагт ийм шинэ таримлуудыг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байгаа юм. Ийм болохоор Атрын 4 дүгээр аян маань талбайгаа нэмж, бүтээмжээ нэмэх ийм бодлого явж байгаа.

Нөгөө талаар энэ бодлоготой хамт төвлөрлийг сааруулах бодлого чинь давхар яваа буюу үйлдвэрлэл дээр ард түмнийг тэнд очих, хөдөө орон нутагт ажиллах амьдрах, бизнес эрхлэх бололцоо бүрдүүлэх зорилгоор л хийгдэж байгаа. Ийм зээл, бодлого, татаас, урамшууллын бодлого явж байгаа. 600 мянган хүний ажлын байрыг хангаж байгаа шүү. Даруухан, тогтвортой орон нутагтай ажиллаж амьдарч байгаа тэр 600 мянган хүний асуудал. Энэ салбараар хамаагүй

оролдох, хөндөх нь тэнд эрсдэлийг их хүчтэй үүсгэнэ. Эргээд л төвлөрөл гадагшаа хүний нөөцөө алдах бодлогыг л өдөөгөөд байгаа юм. Тийм болохоор аль болох хөдөө аж ахуйн салбартаа бодлогын бүх талын дэмжлэг үзүүлж явах хэрэгтэй.

Салбарын явуулж байгаа бодлоготой холбоотойгоор 10 жил 10 хувийн үнэ гурил дээр судалсан. Жилийн инфляцыг давж гурил өсөөгүй юм байгаа юм шүү.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Иргэний зориг ногоон нам Атрын Засгийн газарт төлөөлөн орж ажиллаж Хүнс, хөдөө аж ахуйн яамыг тэргүүлж байх үедээ Атрын 3 дугаар аяныг эхлүүлсэн байдаг. Атрын 3 дугаар аян үр дүнд хүрсэн гэж ойлгож байгаа. Үүнийг бас хэлмээр байна.

Дээрээс нь энэ Евроазийн хэлэлцээртэй холбоотойгоор энэ гаалийн татвар чөлөөлж байгаа зүйл чинь хэр холбогдох юм бэ? Нэг.

Хоёрт нь Засгийн газар 25 оны 1 сарын 23-нд энэ хуулийг өргөн барьсан. Хэрэгжих хугацааг нь 4 сарын 1-нээс гэж тавьсан байсан. Сая 2 Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх хугацааг нь нэгэнт тэр 4 сарын 1 давсан учраас тэрнээс хойш 40 хоног өнгөрч байна. 5 сарын 20-ноос болгож байна. Тэгэхээр төсөл дээрээ 4 сарын 1-нээс хэрэгжинэ гэж байна гэдэг чинь энэ намар гурилтай, буудайтай байх тухай ярьж л бодож л хийсэн байлгүй дээ. Сая салбарын сайд нь намар гурилгүй, будаагүй болох тийм нөхцөл байдал үүслээ гэдгийг тодорхой чуулган дээр хэлээд байна шүү дээ. Энэ салбарын сайд өөрийнхөө бодлогыг Улсын Их Хурал болон Байнгын хороодод ойлгуулж чадахгүй байна уу? Нэг бол өөр гацаа байдаг юм уу? Цаг хугацааны хувьд явсаар байгаад тариаланчдын жилийнхээ бизнес төлөвлөгөөг хийх, ажлаа эмхлэх энэ цаг хугацаа нь давчихсан уу, даваагүй байгаа юу? Намар бид нар буудайтай байх юм уу, гурилтай байх юм уу? Засгийн газар энэ хууль нь өөрчлөгдчихсөн, дутагдал гарлаа гэхэд тэрийгээ зохицуулах тэр төлөвлөгөө байгаа юу, байхгүй юу? Гурил нь, буудай нь алга болоод үнэ нь алга болоод өгвөл Энхбаяр сайд ажлаа хийсэнгүй гэдэг зүйл л ярина шүү дээ.

Ажлаа хийхгүй байгаа бол бас нэг бол ажлаа Их Хуралд ойлгуулж чадахгүй байгаа бол бас тэр ажлыг хийх үү, үгүй юү гэдэг тухай ч гэсэн яригдаж л эхэлнэ. Их Хурлын гишүүд нь сайд нартайгаа хэвлэлээр байлддаг зүйл зөндөө л гарч байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ зүйлээ Засгийн газар Их Хуралд оруулахдаа үнэхээр ингэж буудай тарихааргүй нөхцөл байдалд орно, цаг хугацааны хувьд алдана гэж үзсэн бол ямар ч хэрэггүй хуулиудыг яаралтай горимоор оруулаад л байдаг. 4 улиралтай жилд ганцхан удаа ургац авдаг, газар тариалан, хөдөө аж ахуй, энэ мал аж ахуйн энэ салбарт дөнгөж сая 600 мянган хүний асуудал байна гээд ярьж байдаг ийм юман дээрээ анхаардаггүй юм уу?

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Тантай санал нэг байна. Үнэхээр яг бид нар энэ зүйлийг ярьж байна гэдэг маань өөрөө маш хариуцлагагүй л байдал. Ажил эхэлчихсэн, бүх юм цаг хугацаатай. Нэлээн эргэлзээ үүсгэчихсэн. Улаан буудайн тариалалт багасах байх, намар гурилын асуудал нэлээн асуудал болж орж ирэх байх. Гэхдээ яаралтай энэ асуудлыг л хурдан шийдэж өгөөч би Их Хурлын дарга, эрхэм

гишүүдээс хүсэж байна. Надаа 1 өдөр ч гэсэн үнэтэй байна. Яагаад гэвэл энэ чинь ургамал чинь өөрөө ургадаг цаг хугацаатай, болц нь гүйцдэг учир шалтгаан нь ерөөсөө ингээд. Одоо ингээд хоцроод эхэллээ. 5 сарын 20 хүртэл тариалалт явагдана. Одоо надаа 2 долоо хоног байна. 25-н бодъё л доо. Энэ дотор л улаан буудайн тарилтыг идэвхжүүлэлтийн арга хэмжээг л хийх хэрэгтэй байна.

Яам бүрэн бэлтгэл ханасан. Үр бордоо, техник, шатахуун, ургамал хамгааллын бодис бүрэн, бэлэн байдал хангалттай. Одоо бодлого яаралтай тодорхой болж, тариаланчдыг улаан буудай тарих тэр хүсэл сонирхлыг идэвхжүүлэх хэрэгтэй байна. Бид намрын чуулганд өргөн барьсан. Тодорхой бус олон шалтгаан явсаар байгаад өдийг хүрч байна. Яаралтай л шийдэж өгөөч л гэж хүсээд байна. 6 сарын сүүл, 7 сарын эхэн гэхэд наадам гэхэд ерөнхий ургацын бид нар төлөв байдлыг багцаа авна. Тэгээд улаан буудай, гурил дутна, илүүднэ гэдэг зүйлийг бид нар чуулган тарахаас, хаврын чуулган тарахаас өмнө танилцуулж чадах байх. Тэгээд төсвийн бодлоготой уялдуулаад хэрвээ улаан буудайн тариалалт огцом унавал импортоор бид нар авахаас аргагүй, валют доллароо гадагшаа өгөхөөс аргагүй байдал үүсэх байх.

Гэхдээ одоо хугацаа хэрэгтэй байна. Надаа эцэслэн хурдан баталж өгөөч, шийдэл гаргаж өгөөч ээ би идэвхжүүлэлтийн арга хэмжээг хийх байна. Бас ч бас хоцорчхоогүй байна. Тодорхой хэмжээний эрсдэл үүсэх нь үүсчихсэн байна.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн? Алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн? Алга байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн? Алга байна. Жуковын Алдаржавхлан гишүүн? Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Их Хурлын ажил горимынхоо дагуу явагдаж байгаа шүү Энхбаяр сайд аа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ирц бүртгэе. Ирцийн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүд танхимд орж ирье. Санал хураалт. Гишүүдийн ирц бүрдтэл дараагийн асуудлыг хэлэлцэж байя. Дараагийн асуудалд оръё.

14.42 цаг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-т Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хуулийн эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Гишүүд танхимд орж ирье. Санал хураалт явагдана. Нийт гишүүдийн олонхоор буюу 64 гишүүнээр хуулийн төсөл эцэслэн батлагдана.

Санал хураалтыг ирэх долоо хоногийн чуулган дээр хураая. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулган өндөрлөлөө.

14.48 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР